



ШИНЬ ШИНЬ ХХК

**УЛААНЫ ОРДООС ХОЛИМОГ МЕТАЛЛ ОЛБОРЛОХ
БАЯЖУУЛАХ ТӨСӨЛ**

**ДОРНОД АЙМГИЙН ДАШБАЛБАР СУМЫН НУТАГТ
БАЙРЛАХ УЛААНЫ ОРД ТӨСЛИЙН 2024 ОНЫ
БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН
ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН**


**ДОРНОД АЙМАГ
2024 ОН**

2024 ОНД ХЭРЭГЖҮҮЛСЭН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН

/ АШИГТ МАЛТМАЛЫН ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ДУГААР **MV-000247** /

/ АЖ АХУЙ НЭГЖИЙН РЕГИСТЕРИЙН ДУГААР **2830213** /

БИЕЛЭЛТИЙГ ГАРГАСАН:


ШИНЬ ШИНЬ ХХК-ИЙН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАА  СУН ГҮЙ МИН

ШИНЬ ШИНЬ ХХК-ИЙН ХӨДӨЛМӨР ХАМГААЛАЛ
АЮУЛГҮЙ АЖИЛЛАГАА БАЙГАЛЬ ОРЧНЫ
ХЭЛТСИЙН ДАРГА



ВАН МИН ШАНЬ

ШИНЬ ШИНЬ ХХК-ИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ
АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН



Э. ГЭРЭЛТУЯА

ШИНЬ ШИНЬ ХХК-ИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ
МЭРГЭЖИЛТЭН



Б. АМЬДРАЛ

2024 он

АГУУЛГА

Зургийн жагсаалт	3
1. Төслийн танилцуулга	6
1.1.ТӨСӨЛ ХЭРЭГЖИЖ БУЙ НУТГИЙН БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМ-ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВ БАЙДЛЫН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА.....	7
1.1.1. Физик газарзүй	7
1.1.2. Уур амьсгал.....	7
1.2. Агаарын чанар	13
1.3. Гадаргын болон газрын доорхи усны чанар.....	15
1.4. Хөрсөн бүрхэвч	16
1.5. Ургамлан нөмрөг.....	18
1.6. Нийгэм-эдийн засгийн төлөв байдлын товч танилцуулга.....	21
1.7.Төслийн гол болон болзошгүй сөрөг нөлөөллийн товч тодорхойлолт	23
1.8. Нөлөөлийн хэлбэр, үргэлжлэх хугацаа	27
1.9. Экосистемийн бүрэлдэхүүн хэсгүүдэд нөлөөлөх байдал.....	28
1.10. Тухайн жилийн байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөний гол зорилт, хамрах хүрээ	30
2.Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө	31
2.1. Агаар орчинд үзүүлэх нөлөөллийг бууруулах чиглэлээр	31
2.2. Гадаргын болон газрын доорхи усанд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах чиглэлээр	31
2.2.1. 2024 оны усны хэрэглээ, ашиглалт.....	31
2.2.2. 2024 оны ус ашиглалт, төлбөр тооцоо	33
2.3. Хөрсөн бүрхэвчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах чиглэлээр.....	39
2.4. Ургамлан нөмрөгийг хамгаалах чиглэлээр	39
2.5. Физик нөлөөллийг бууруулах чиглэлээр	40
2.6. Хүний эрүүл мэнд	40
3. Нөхөн сэргээлтийн төлөвлөгөө	40
4. Биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах арга хэмжээ	42
5. Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээ	43
6. Түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээ.....	43
7. Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөө.....	43
7.1. Химийн бодисын төрөл хэмжээ, хэрэглээ	43
7.2. Тохиолдож болзошгүй эрсдэл.....	44
7.3. Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөө	44
7.3.1. Байгалийн гамшгаас урьдчилан сэргийлэх чиглэлээр	44
7.3.2. Үйлдвэрлэлийн ослоос урьдчилан сэргийлэх чиглэлээр	47
7.4. Химийн бодисийн эрсдэлийг бууруулах чиглэлээр авч хэрэгжүүлэх арга хэмжээ	50
8. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө	53
8.1. Ахуйн хог хаягдлын арга хэмжээний төлөвлөгөө.....	54
8.2. Үйлдвэрийн хог хаягдлын арга хэмжээний төлөвлөгөө	56
8.3. Аюултай хог хаягдлын арга хэмжээний төлөвлөгөө	56
9. Орчны хяналт-шинжилгээний хөтөлбөр	57
9.1. Агаарын бохирдлыг хянах.....	57
9.2. Усны бохирдлыг хянах.....	58
9.3. Хөрсний бохирдлыг хянах	68
9.4. Цацрагийн бохирдлыг хянах	73
9.5. Ургамлан бүрхэвч, амьтны аймгийн хяналт шинжилгээ.....	85

9.5.1. Ургамлан бүрхэвчийн мониторинг судалгааны ажил	85
9.5.2. Амьтны аймгийн мониторинг судалгааны ажил	86
10. Аймаг нийслэлийн засаг даргын шаардлагаар биелүүлсэн арга хэмжээ.....	86
11. Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө	87
12. Нийгмийн хариуцлагын хүрээнд хийгдсэн ажил	94
13. БОМТ, түүний хэрэгжилтийг оролцогч, сонирхогч талуудад тайлагнах, хэлэлцүүлэх хуваарь	94
14. Дүгнэлт	96

Хүснэгтийн жагсаалт

Хүснэгт 1. Талбайн солбицлууд	7
Хүснэгт 2. Хэмжилтийн үр дүн	13
Хүснэгт 3. Нөлөөллийн эх үүсвэр	24
Хүснэгт 4. Нөлөөлөлд өртөж буй газрын хэмжээ	27
Хүснэгт 5. Нөлөөлөлд өртөх экосистемүүд	27
Хүснэгт 6. Ус ашиглах зориулалт, усны төлбөрийн хувь хэмжээ	32
Хүснэгт 7. Усны тоолуурын баталгаажуулалт хийсэн дэлгэрэнгүй мэдээлэл	33
Хүснэгт 8. Улааны орд төслийн нөхөн сэлбэлтээр ашигласан усны нийт хэмжээг хэрэглээний төрлөөр (ашиглалтын худгуудын баталгаат усны тоолуурын заалтаар тооцсон)	34
Хүснэгт 9. 2024 оны ус ашиглалтын төлбөрийн гүйцэтгэл	35
Хүснэгт 10. Ахуйн бохир усны химийн үзүүлэлт	37
Хүснэгт 11. Ахуйн бохир усны химийн үзүүлэлт	Error! Bookmark not defined.
Хүснэгт 12. Ахуйн бохир ус цэвэрлэх байгууламжаас эргүүлэн ашигласан ус	38
Хүснэгт 13. Ногоон байгууламжинд тариалалт хийсэн талбайн дэлгэрэнгүй	39
Хүснэгт 14. 2024 онд хийгдсэн нөхөн сэргээлтийн мэдээ	40
Хүснэгт 15. Химийн бодисын хэрэглээ	43
Хүснэгт 16. Сургалтын тоон мэдээлэл	48
Хүснэгт 17. Гар хамгаалах хэрэгсэл олголт	50
Хүснэгт 18. Нүүр, нүд, толгой хамгаалах хэрэгсэл олголт	50
Хүснэгт 19. Ажлын тусгай хувцас олголт	50
Хүснэгт 20. Химийн бодисын ашиглалт	52
Хүснэгт 21. 2024 оны агаарын найрлагын шинжилгээний дүн	57
Хүснэгт 22. Үйлдвэрийн усан дахь хүнд металлын дээж авсан цэгүүдийн байршил	59
Хүснэгт 23. Уурхайн бүсийн ундны усны дээж авсан цэгүүдийн байршил	63
Хүснэгт 24. Ундны усан дахь хүнд металлын агууламж	66
Хүснэгт 25. Уурхайн бүсийн ойр орчмын ундны усны дээж авсан цэгүүдийн байршил	67
Хүснэгт 26. Хөрсний хүнд металлын дээж авсан цэгүүдийн байршил	69
Хүснэгт 27. Хөрсний нефть бүтээгдэхүүний дээж авсан цэгүүдийн байршил	72
Хүснэгт 28. Хөрсний нефть илэрцийн агууламж	72
Хүснэгт 29. Багажны товч танилцуулга	73
Хүснэгт 30. Хяналтын болон ажиглалтын бүсийн байршил	74
Хүснэгт 31. Ажиглалтын бүс дэх тосгоны агаар дахь радоны хуримтлалын дундаж утга... ..	74
Хүснэгт 32. Ажиглалтын бүс дэх баяжуулах үйлдвэрийн агаар дахь радоны хуримтлалын дундаж утга	75
Хүснэгт 33. Ажиглалтын бүс дэх тосгоны гамма цацрагийн тунгийн чадлын дундаж утга.. ..	76

Хүснэгт 34. Ажиглалтын бүс дэх баяжуулах үйлдвэрийн гамма цацрагийн тунгийн чадлын дундаж утга	77
Хүснэгт 35. Ажиглалтын бүс дэх хүдэр тээвэрлэх зам дагуух гамма цацрагийн тунгийн чадлын дундаж утга	78
Хүснэгт 36. Хяналтын бүс дэх налуу амны агаар дахь радоны хуримтлалын дундаж утга	79
Хүснэгт 37. Хяналтын бүс дэх налуу амны гамма цацрагийн тунгийн чадлын дундаж утга.....	80
Хүснэгт 38. Хяналтын бүс дэх гадаргуугийн бохирдолтын хэмжилтийн дундаж утга.....	81
Хүснэгт 39. Уурхайн талбайн орчмын малчин өрхийн гамма цацрагийн тунгийн чадал.....	82
Хүснэгт 40. Усанд изотопуудын хувийн идэвх тодорхойлсон лабораторийн шинжилгээний хариу.....	83
Хүснэгт 41. Малчин өрхийн ундны усанд изотопуудын хувийн идэвх тодорхойлсон лабораторийн шинжилгээний хариу.....	84
Хүснэгт 42. Хөрс, хүдэр, хаягдал шороонд изотопуудын хувийн идэвх болон элементийн агуулалт, шингэсэн тунгийн чадлыг тодорхойлсон лабораторийн шинжилгээний дундаж утга.....	85
Хүснэгт 43. Байгаль орчны менежментийн төлөвлөгөө хэрэгжүүлсэн зардал.....	96

Зургийн жагсаалт

Зураг 1. Төслийн байршил	6
Зураг 2. Жилийн дундаж агаарын температурын явц /Дашбалбар сум 2010-2019/	8
Зураг 3. Сарын дундаж агаарын температурын явц /Дашбалбар сум 2010-2019/	8
Зураг 4. Жилийн дундаж хөрсний гадаргын температурын явц /Дашбалбар сум 2010-2019/	9
Зураг 5. Сарын дундаж хөрсний гадаргын температурын явц /Дашбалбар сум 2010-2019/	9
Зураг 6. Нийлбэр хур тунадас /2010-2019/	10
Зураг 7. Хур тунадасны сарын хуваарилалт /2010-2019/	10
Зураг 8. Харьцангуй чийгшлийн жилийн явц (Дашбалбар станц, 2010-2019).....	11
Зураг 9. Харьцангуй чийгшлийн сарын явц (Дашбалбар станц, 2010-2019).....	11
Зураг 10. Салхины дундаж хурдны жилийн явц /2010-2019 он/	12
Зураг 11. Салхины дундаж хурдны сарын явц /2010-2019 он/	12
Зураг 12. Сүүлийн жилүүдэд ажиглагдсан салхины чиглэлийн давтагдал, %/2010-2019/ ..	12
Зураг 13. Агаарын дээж авсан цэгүүдийн байршил	14
Зураг 14. Агаарын хэмжилт хийсэн цэгүүд /А. Хүдрийн овоолгын хойно, Б.Уурхайн ам орчим/	14
Зураг 15. Улз голын сав газар	15
Зураг 16. Төслийн талбайн төрх /2020.05 сар/.....	16
Зураг 17. MV-000247 тоот тусгай зөвшөөрөлтэй талбай орчмын топо зураг.....	17
Зураг 18. MV-000247 тоот тусгай зөвшөөрөлтэй талбай орчмын өндөржилтийн зураг.....	17
Зураг 19. Төсөл хэрэгжих орчны хөрсний хэв шинж	18
Зураг 20. Төслийн талбайн ургамал газарзүйн байршил	18
Зураг 21. Төслийн талбайн ургамлан бүлгэмдэл.....	20
Зураг 22. Дорнод аймаг	21
Зураг 23. Дорнод аймгийн дотоодын нийт бүтээгдэхүүн	22
Эх сурвалж: www.1212.mn	22

Зураг 24. Хүн ам, өрхийн тоо /Дашбалбар сум/	22
Зураг 25. Нөлөөллийн эрчимшлийн ангилал, өртөх талбайн хэмжээ	26
Зураг 26. Усны эх үүсвэрүүд	32
Зураг 27. Дэлхийн усны өдрийг тохиолдуулан зохион байгуулсан сургалт	36
Зураг 28. Цэнхэр тууз аянд нэгдсэн нь	36
Зураг 29. Ахуйн бохир усны дээжлэлт.....	37
Зураг 30. Тариалалтын ажлын явц.....	41
Зураг 31. Усалгааны ажлын явц	41
Зураг 32. Тариалалтын дараах байдал	42
Зураг 33. Манан болон шороон шуургатай үеийн нөхцөл байдал.....	44
Зураг 34. Танхимын сургалт.....	45
Зураг 35. Практик сургалт	46
Зураг 36. Галын хор болон гал унтраах багаж хэрэгслийг шалгаж байна.....	46
Зураг 37. Дуут дохиолол шалгаж байна	47
Зураг 38. Үйлдвэрийн хэлтэс цехүүдээр хяналт шалгалт хийж байна	48
Зураг 39. Сургалтын үеэр.....	48
Зураг 40. Дотооддоо зохион байгуулсан нийт ажилтны сургалт.....	49
Зураг 41. Мэргэжлийн байгууллагын сургалт.....	49
Зураг 42. ХАЛ болон тараах материал.....	51
Зураг 43. Сургалтын үеэр	51
Зураг 44. Химийн бодис буулгаж буй үед хяналт тавьж байна.....	53
Зураг 45. Сургалтын гэрчилгээ.....	53
Зураг 46. Сургалт мэдээлэл хүргэж буй нь.....	54
Зураг 47. Хог хаягдлын цэгийн камержуулалт.	54
Зураг 48. Ангилан ялгалтын хогийн сав	55
Зураг 49. Бүх нийтийн цэвэрлэгээний үеэр.....	56
Зураг 50. Дахин ашиглах барилгын хог хаягдал	56
Зураг 51. Үйлдвэрийн оффис, эмнэлэгийн агаар дахь радоны хуримтлалын хэмжилт	75
Зураг 52. Флотацн машины агаар дахь радоны хуримтлалын хэмжилт	76
Зураг 53. Гал тогоо, зочид буудлын гамма цацрагийн тунгийн чадлын хэмжилт	77
Зураг 54. Гамма цацрагийн тунгийн чадлын хэмжилт	78
Зураг 55. Хүдэр тээвэрлэх зам дагуух гамма цацрагийн тунгийн чадлын хэмжилт	79
Зураг 56. Налуу ам 825 түвшний гамма цацраг болон радоны хэмжилт.....	80
Зураг 57. Хүдэр тээвэрлэлтийн ачааны машины гадаргуугийн бохирдолтын хэмжилт	81
Зураг 58. Малчин М.Миш-Ишийн гэрийн ойр орчмын гамма цацрагийн тунгийн чадлын хэмжилт	83
Зураг 59. “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөнд нэгдэж мод тарьж буй нь.	88
Зураг 60. Шувуу үргээгч толь суурилуулж буй нь	88
Зураг 61. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн дээжлэлт.....	89
Зураг 62. Дотоод хяналт шалгалтын ажлын явц.....	90
Зураг 63. Ослын үед авах арга хэмжээний төлөвлөгөө.....	90
Зураг 64. Дуут дохиоллын систем суурилуулсан нь	90
Зураг 65. Ургамлын үр түүх, хадгалах	91
Зураг 66. Ногоон байгууламжийн хашаажуулалтын ажил.....	91
Зураг 67. Булгийн эхийн хашаажуулалт	92
Зураг 68. Гүний усан дахь мод тарилт.....	92
Зураг 69. Хэрэглэгдэхүүн хүлээлцэж буй нь	92
Зураг 70. Их засварын ажил.....	93
Зураг 71. “Шинь Шинь” ХХК-ийн ус ашиглалттай танилцах өдөрлөг	94

Зураг 72. Хамтран ажиллах гэрээ байгуулж буй нь.....	93
Зураг 73. Оролцогч талуудад тайлагнах өдөрлөгийн үеэр.....	94
Зураг 74. Уурхайтай танилцах өдөрлөгийн үеэр.....	95

Графикийн жагсаалт

График 1. Улааны орд төслийн нөхөн сэлбэлтээр ашигласан ус.....	34
График 2. Ус ашиглалтын төлбөрийн дүн.....	35
График 3а-е. Үйлдвэрийн усан дахь хүнд металлын агуулга.....	60
График 4а-в. Ундны усан дахь химийн үзүүлэлт.....	64
График 5а-в. Уурхайн бүсийн ойр орчмын усан дахь химийн үзүүлэлт.....	67
График 6а-е. Хөрсөн дэх хүнд металлын агуулга.....	69


1. ТӨСЛИЙН ТАНИЛЦУУЛГА

Улааны холимог металлын орд нь Монгол улсын нийслэл Улаанбаатар хотоос зүүн хойд зүгт 790 км, Дорнод аймгийн төв Чойбалсан хотоос хойд зүгт 130 км, Дорнод аймгийн Дашбалбар сумын төвөөс баруун урд зүгт 70 км зайд алслагдсан Дорнод аймгийн Дашбалбар сумын нутагт оршино.

Дорнод аймгийн Дашбалбар сумын нутагт орших Улааны холимог металлын ордыг эдийн засгийн үр ашигтайгаар ашиглах, Монгол улсад хүчин төгөлдөр мөрдөгдөж буй холбогдох хууль, дүрэм журам, стандартын дагуу үйл ажиллагаагаа явуулж, улс орон нутагт татвар төлбөрүүдийг төлөх, ордын хүрээлэн буй талбайн байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээлт хийх, шинээр ажлын байр бий болгох, ордын үр ашгийг улс, орон нутаг болон төсөл хэрэгжүүлэгч компанид хүртээхэд уг төслийн зорилго оршино.

Улааны холимог металлын ордын нөөц нь “Шинь Шинь” ХХК-ийн MV-000247 ба “Хунбөө” ХХК-ийн MV-013555 ашиглалтын тусгай зөвшөөрлүүдийн талбайд дамнан байрладаг. ТЭЗҮ-ийн нэмэлт тодотголоор уурхайн дэргэдэх баяжуулах үйлдвэрийн хүчин чадалд тулгуурлан, төсөл хэрэгжүүлэгч байгууллагын төсөл боловсруулах техникийн даалгаврын дагуу далд уурхай нь 900 мян.тн хүдэр олборлох хүчин чадалтай байхаар тооцоолжээ. Дээрх компаниудын тусгай зөвшөөрлийн талбайнуудаас олборлох хүдрийн харьцаа нь ордын гүнзгийрэлттэй шууд хамааралтайгаар тодорхойлогдох ба MV-000247 талбайгаас жилд 800-356.4 мян.тн, MV-013555 талбайгаас жилд 100-430.3 мян.тн хүдэр олборлон баяжуулахаар байгаа бөгөөд тус уурхай нь 2019 оноос бүрэн хүчин чадлаараа ажиллаж байна.

Дээрх хүчин чадлаар Улааны холимог металлын ордыг ашиглах хугацаа нийт 33 жил байна.



Зураг 1. Төслийн байршил

Ашиглалтын тусгай зөвшөөрлийн талбай нь дараах солбицлоор хязгаарлагдана.

Хүснэгт 1. Талбайн солбицлууд

MV-000247 тоот тусгай зөвшөөрлийн талбай		
#	Уртраг	Өргөрөг
1	114°04'30"	49°05'10"
2	114°05'30"	49°05'10"
3	114°05'30"	49°04'43"
4	114°04'30"	49°04'43"

1.1.ТӨСӨЛ ХЭРЭГЖИЖ БУЙ НУТГИЙН БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМ-ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВ БАЙДЛЫН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

1.1.1. Физик газарзүй

Уурхайн орд газар нь нам уулс, ухаа гүвээ, толгодоор хүрээлэгдсэн, толгодын орой хяр нь бөөрөнхий хавтгайдуу оройтой, уулын ар хажуу нь нилээд огцом, эдгээрийн хооронд нарийвтар хөндийнүүдтэй байна. Уурхай орчмын газар нутаг нь физик газарзүйн мужлалаар Монголын дорнод талын их мужийн Дорнодын тэгш талын мужийн Хэрлэнгийн хойд талын тойрогт багтана.

1.1.2. Уур амьсгал

Дорнод аймгийн Дашбалбар сум орчмын уур амьсгалыг тодорхойлж, үнэлэх судалгааны ажлын хүрээнд цаг уурын Дашбалбар станцын 2010-2019 оны мэдээг ашигласан болно. /Эх сурвалж: Цаг Уур Орчны Шинжилгээний Газар, Архив Мэдээллийн Сангийн хэлтэс/


Агаарын температур

Агаарын сарын дундаж температурын агууриг 42.0°C байна. Үнэмлэхүй агууриг нь 45.2°C хүрдэг байна. Агаарын температур тодорхой илэрсэн жил, хоногийн явцтай байдаг. Жилийн явцад агаарын температурын их утга нь зуны 7 дугаар сард, бага утга нь өвөл 1 дүгээр сард тус тус ажиглагддаг байна. Жилийн хамгийн дулаан 7 дугаар сарын дундаж агаарын температур +19.2°C хамгийн хүйтэн 1 дүгээр сарын дундаж температур -19.2°C байна. Агаарын үнэмлэхүй хамгийн их температур 2016 оны 8 дугаар сард +41.4°C хүрч дулаарсан бол үнэмлэхүй хамгийн бага температур 2012 оны 01 дүгээр сард -41.7°C хүрч хүйтэрсэн байна.

Үйл ажиллагаа явуулж буй талбай орчмын агаарын температурыг Дашбалбар станцын 2010-2019 оны мэдээнд тулгуурлан Зураг 2, 3-т үзүүлээ.



Зураг 2. Жилийн дундаж агаарын температурын явц /Дашбалбар сум 2010-2019/



Зураг 3. Сарын дундаж агаарын температурын явц /Дашбалбар сум 2010-2019/


Хөрсний гадаргын температур

Хөрсний гадаргын сарын дундаж температурын агууриг 49.3°C байна. Үнэмлэхүй агууриг нь 53.7°C хүрдэг байна. Жилийн явцад хөрсний гадаргын температурын их утга нь зуны 7 дугаар сард, бага утга нь өвөл 1 дүгээр сард тус тус ажиглагддаг байна. Жилийн хамгийн дулаан 7 дугаар сарын дундаж хөрсний температур +23.6°C хамгийн хүйтэн 1 дүгээр сарын хөрсний гадаргын дундаж температур -21.3°C байна.

Үйл ажиллагаа явуулж буй талбай орчмын хөрсний гадаргын температурыг Дашбалбар станцын 2010-2019 оны мэдээнд тулгуурлан Зураг 4, 5-т үзүүллээ.



Зураг 4. Жилийн дундаж хөрсний гадаргын температурын явц /Дашбалбар сум 2010-2019/




Зураг 5. Сарын дундаж хөрсний гадаргын температурын явц /Дашбалбар сум 2010-2019/


Хур тунадас

Тухайн бүс нутагт жилдээ дунджаар 260 мм хур тунадас ордог байна. Уур амьсгалын дулааралт, хуурайшилтын үйл явц сүүлийн жилүүдэд мэдэгдэхүйц илэрч байна. 2010-2019 онуудад тус аймагт 137.9-369.0 мм тунадас унасан байна. Жилд орох хур тунадасны дийлэнхи хувь нь зуны улиралд буюу 6, 7, 8-р саруудад ордог байна.

Жилд орох хур тунадасны нийлбэр хэмжээг 2010-2019 онуудын мэдээнд үндэслэн Зураг 6, 7-д үзүүллээ.



Зураг 6. Нийлбэр хур тунадас /2010-2019/




Зураг 7. Хур тунадасны сарын хуваарилалт /2010-2019/


Хур тунадасны жилийн нийлбэрийн сүүлийн жилүүдийн өөрчлөлтийг авч үзэхэд төсөл хэрэгжих талбайн орчмоор сүүлийн жилүүдэд буурсан хандлагатай байсан боловч 2014 онд 369.0 мм, 2018 онд 301.2 мм тунадас унасан байна.

Агаарын чийгшил

Дорнод аймгийн Дашбалбар сумын нутагт жилийн дундаж харьцангуй чийгшил 64.3 % байна. Харьцангуй чийгшил 1 дүгээр сард хамгийн их утгатай 74.2%, 4 дүгээр сард хамгийн бага утгатай 47.7% болно.



Зураг 8. Харьцангуй чийгшлийн жилийн явц (Дашбалбар станц, 2010-2019)




Зураг 9. Харьцангуй чийгшлийн сарын явц (Дашбалбар станц, 2010-2019)

Салхи

Дорнод аймаг нь хээрийн бүсэд хамаарагдах ба нөмөрлөж хаах уул, нуруу багатай учраас салхитай нутагт хамаарагдана. Гэхдээ хүчтэй шуургалж салхилах нь ховор. Олон жилийн дунджаас үзэхэд салхигүй намуун үе нийт ажиглалтын 15.3 хувьд байдаг байна. Салхины зонхилох чиглэл баруун ба баруун хойд талаасаа байдаг.



Зураг 10. Салхины дундаж хурдны жилийн явц /2010-2019 он/



Зураг 11. Салхины дундаж хурдны сарын явц /2010-2019 он/



Зураг 12. Сүүлийн жилүүдэд ажиглагдсан салхины чиглэлийн давтагдал, % /2010-2019/


1.2. АГААРЫН ЧАНАР

“Шинь Шинь” ХХК-ийн “Улааны холимог металлын ордыг далд уурхайн аргаар ашиглах” төсөл хэрэгжих орчны агаарын чанарын төлөв байдлыг тодорхойлох ажилд 2020 оны 05-р сарын 08-09-ний өдөр хийсэн агаарын чанарын хэмжилтийн үр дүнг ашиглав.

Агаарын хяналт-шинжилгээний ажлын хүрээнд эх үүсвэрүүдийг нарийвчлан тогтоож, төслийн үйл ажиллагаа тогтмол явагддаг газруудад 10 цэг сонгон азотын давхар исэл, хүхэрлэг хий, том ширхэглэгт тоосонцор гэсэн үзүүлэлтүүдээр 2020 оны 05 дугаар сарын 08, 09-ний өдрүүдэд хэмжилтийг хийж гүйцэтгэсэн. Нарийн ширхэглэгт тоосонцорын агууламжийг тогтооход Dusttrak Pro 8530, түгээмэл бохирдуулагч бодисуудын судалгаанд агаар сорох насос, агаарын даралт чийг, температур хэмжигч гар багаж зэрэг багаж төхөөрөмжүүдийг ашигласан.

Хүснэгт 2. Хэмжилтийн үр дүн

№	Агаарын сорьц авсан цэгийн нэр	Байршил	Агаарын даралт	Агаарын температур	Азотын давхар исэл	Хүхэрлэг хий	Нийт тоос
			гПа	°C	мкг/м ³	мкг/м ³	мкг/м ³
1	Уурхайн ам	49°05'05.8" 114°05'01.3"	695	13.6	14	7	63
2	Бутлуур	49°04'53.4" 114°05'54.1"	694.7	14.3	20	5	15
3	Баяжуулах үйлдвэрийн гадна	49°04'48.2" 114°05'44.4"	694.4	15	12	3	7
4	Кемпийн орчим	49°04'38.2" 114°05'49.0"	693.2	16.6	4	2	8
5	Хаягдлын сангийн орчим	49°04'58.8" 114°06'38.3"	691.9	19.2	12	7	10
6	Буцах усан сан	49°05'12.8" 114°06'38.8"	691.4	19.3	10	7	7
7	Тээврийн зам дагуу	49°04'12.8" 114°06'38.5"	690.8	19.5	15	2	13
8	Хүдрийн овоолгын хойно	49°05'09.6" 114°04'48.1"	690.5	19.8	27	3	5
9	Ус хангамжийн эх үүсвэр	49°13'29.8" 114°03'04.6"	689.2	15.8	25	4	20
10	Малчин айлын гадна	49°06'23.5" 114°06'04.4"	689	16.9	16	197	23
Агаарын чанар. Техникийн ерөнхий шаардлага (MNS4585:2016)					200	450	500



Зураг 13. Агаарын дээж авсан цэгүүдийн байршил

Хэмжилтийн үр дүнгээс харахад нийт тоос уурхайн амны хэсэгт хамгийн өндөр 63 мкг/м^3 , азотын давхар исэл хүдрийн овоолгын хойно хамгийн өндөр 27 мкг/м^3 , хүхэрлэг хий малчин айлын гадна хамгийн өндөр 197 мкг/м^3 байгаа боловч “Агаарын чанарын стандарт MNS 4585:2016”- аас давсан үзүүлэлт байхгүй байна.



А.




Б.

Зураг 14. Агаарын хэмжилт хийсэн цэгүүд /А. Хүдрийн овоолгын хойно, Б. Уурхайн ам орчим/

1.3. ГАДАРГЫН БОЛОН ГАЗРЫН ДООРХИ УСНЫ ЧАНАР

Монгол орны гол, мөрөн, түүний сав газрын хэмжээ, байгалийн нөхцөл, урсац бүрэлдэх зүй тогтол, нөөцийн хуваарилалт, байгалийн болон засаг захиргааны хил хязгаарыг үндэслэн Байгаль орчин, Аялал жуулчлалын сайдын 2009 оны 332 дугаар тушаалаар Монгол орны нутаг дэвсгэрийг усны 29 сав газарт хувааж, хил хязгаарыг нь тогтоож өгсөн байдаг бөгөөд тус төсөл хэрэгжих нутаг дэвсгэр нь Улз голын сав газарт хамаарна. Улз голын сав газрын байршлыг дараах зургаар харуулав.



Зураг 15. Улз голын сав газар

Улз голын сав газар нь Монгол орны зүүн хойд хэсэгт орших Дорнодын талд ойролцоогоор 38,000 км²-ыг эзлэн Хэнтий аймгийн Норовлин, Батноров, Дадал, Баян-Адарга сумд болон Дорнод аймгийн Баян-Уул, Баяндун, Дашбалбар, Гурванзагал, Чойбалсан, Сэргэлэн, Чулуунхороот зэрэг нийт 11 сумын нутаг дэвсгэрийг дамнан оршдог. Улз голын сав газрын 89.8 хувийг Дорнод, 7.4 хувийг Хэнтий аймаг, 2.8 хувийг ОХУ, мөн багагүй хэсгийг БНХАУ-ын нутаг дэвсгэрийг хамарч тогтсон байна.

“Улааны холимог металлын ордын усны хэрэгцээг Сосновын экспедицийн гидрогеологийн ангийн Сэвсүүлийн голын хөндийд тогтоосон газар доорх усны ордоос хангадаг байна. Сэвсүүлийн голын хөндийн хэсэг нь төсөл хэрэгжих талбайгаас хойш 18 км зайд оршино. Тус газрын доорх усны ордын нөөц нь үйлдвэрлэлийн зэргээр (A+B+C1) 17885 м³/хон, 207 м³/цаг буюу 57.5 л/сек байна. Иймд “Улааны ордыг ашиглах” төслийн 35.8 л/сек хэрэгцээг хангах боломжтой нь харагдаж байна.

Сэвсүүлийн голын хөндий нь геологи-гидрогеологийн төрөл бүрийн түвшний судалгаанд хамрагдсан, газрын доорх усны ордын ашиглалт явагдаж байсан талбай юм. Тухайлбал, 1980-1984 онд В.А.Манукян, Е.Ф.Гаркушин, А.М.Таболлина нар ус хангамжийн 2289 тоот даалгаврын дагуу ус хэрэглэгчээс 50 км радиус талбайд ус хангамжийн эх үүсвэр илрүүлэхээр Улз, Сэвсүүл, Мардайн голын хөндийд

гидрогеологийн судалгаа явуулсан. Уг судалгааны ажлыг 1980-1982 онд эрлийн шатны ажлаар эхлүүлсэн бөгөөд 50 км радиус бүхий 16,238 кв.км талбайд геологи-гидрогеологийн нөхцлийг судалжээ. Гидрогеологийн урьдчилсан хайгуулын ажил 1983 оны 1-р сараас 1984 оны 6-р сарын хугацаанд хийгдсэн байна. Судалгааны ажлын цар хүрээ маш өргөн хэмжээнд хийгдсэн бөгөөд өрөмдлөг, шавхалт болон гидрохимийн лабораторийн ажлууд иж бүрнээр хийгджээ. Судалгааны үр дүнд Сэвсүүлийн голын хөндийг 2 хэсэгт хувааж нэгдүгээр хэсэг буюу Ногоон бүрдийн хэсэгт ашиглалтын нөөцийг В+С1 зэргээр 75 л/с буюу 6480 м³/хон, 2-р хэсэг буюу доод хэсгээс ашиглалтын В+С1 зэргээр 225 л/с буюу 19440 м³/хон гэж тогтоожээ.

Баруун Сүүжийн булаг (нутгийн зарим иргэд Жараахай булаг гэж нэрлэдэг) нь уурхайн тосгоноос баруун хойш 3 км зайд урсана. Тус булаг гантай жилүүдэд ширгэдэг, бусад үед байнгын устай байдаг байна.

Уурхайн усан хангамжинд зориулан 2007 онд “Гидро-фонтан” ХХК-ийн боловсруулсан зураг төслийн дагуу Сэвсүүлийн хөндийн Ногоон бүрдийн хэсэгт нийт 9 худаг/цооногийг 42.5-57 метрийн гүнтэй өрөмдөж 370 мм-ийн шүүр яндангаар тоноглон ус татах байгууламжуудыг хийж гүйцэтгэсэн байна. Цооног хоорондын зай 506.6 м. Одоогийн байдлаар 7 цооногийг унд-ахуйн болон технологийн хэрэгцээнд ашиглаж байна.

1.4. ХӨРСӨН БҮРХЭВЧ

Улааны уурхай орчмын газар нутаг нь физик газарзүйн мужлалаар Монголын дорнод талын их мужийн Дорнодын тэгш талын мужийн Хэрлэнгийн хойд талын тойрогт багтана.

Газрын гадаргын хувьд Дорнодын тал нутаг нь хуурайсаг өндөрлөг хээрийн ерөнхий хэв шинжтэй. Тус нутаг дэвсгэр нь олон зүйлийн өвс ургамал, ховорхон тохиолдох хус, нарс, бут сөөгт төгөл бүхий дугуй хэлбэрийн намхан толгод, алгуур намсч тал хөндий үргэлжилнэ.


Тус нутаг дэвсгэр нь д.т.д 900-1071 м-т орших газрын гадаргын намаас дундаж орчим өндөршилтэй. Төслийн талбай орчмын хамгийн өндөр цэг нь төслийн талбайгаас урагш орших Мухар хөв уул д.т.д 1131.7 м өндөртэй байна.



Зураг 16. Төслийн талбайн төрх /2020.05 сар/




Зураг 17. MV-000247 тоот тусгай зөвшөөрөлтэй талбай орчмын топо зураг



Зураг 18. MV-000247 тоот тусгай зөвшөөрөлтэй талбай орчмын өндөржилтийн зураг


Төслийн талбайд хамаарах газар нь 920-1120 метрийн үнэмлэхүй өндөртэй нам уулс болон тэдгээрийн хоорондох бэл хөндий бүхий газарт байрлана. Төслийн талбайд тархсан хөрсөн бүрхэвч нь Монгол орны хөрсний ангиллаар хээрийн бүлэг хөрсний Хар шороон ба Хар хүрэн хөрсний дэд хэв шинжид багтах чулуурхаг Харшороон, ердийн Хар шороон, ердийн Хар хүрэн хөрснүүд зонхилон тархсан байна. Хар шороон хөрс нь үржил шимийн түвшин өндөр, Хар хүрэн хөрс нь дунд зэрэг, бэлчээрт зонхилон ашиглагддаг (Зураг 19). Төслийн талбайд зонхилон тархсан хөрсний гадаргын ба үе давхаргын морфологи шинж чанар болон агрохими, ус физик шинж чанарын талаар доор дэлгэрэнгүй оруулсан.



Зураг 19. Төсөл хэрэгжих орчны хөрсний хэв шинж

1.5. УРГАМЛАН НӨМРӨГ

“Улаан” холимог металлын орд нь засаг захиргааны харъяаллаар Дорнод аймгийн Дашбалбар сумын нутаг ургамал – газарзүйн тойргоор Монгол – Дагуурын уулын ойт хээр болон Дорнод Монголын хээрийн тойргийн хил залгаа бүс нутагт хамаарах (Н.Өлзийхутаг, 1988) бөгөөд Дорнод Монголын хээрийн, Монгол дагуурын ойт хээрийн болон Дорнод Азийн ургамлын аймгийн төлөөлөгчдөөс тохиолдох онцлогтой. (Зураг 20).




Зураг 20. Төслийн талбайн ургамал газарзүйн байршил

Энэ бүс нутаг нь Монгол дагуурын ойт хээр болон Дорнод Монголын хээрийн шилжилтийн бус учир хойноосоо ойт хээрийн ургамалжилтын нөлөө, зүүн өмнөд, өмнөд хэсгээсээ хуурай хээрийн ургамалжилтын нөлөөллүүд илэрнэ.

Улааны холимог металлын ордын талбайд Монгол дагуурын ойт хээрийн ургамалжилтын төлөөлөл болох Нарс – Хусан ой уулын ар, хажуу бэлээр бага хэмжээтэй тохиолдох бөгөөд энд нарс бага хэмжээтэй армаг тармаг байдалтай ганц нэгээр түлхүү тохиолдоно. Энэ нь тухайн бүс нутаг нь ойт хээрийн хамгийн өмнөд зах болохыг шууд илтгэх бөгөөд харин уул толгодоос доошлох тутам уулын хээр, нугажуу хээр нь үетэнт хээрээр солигдож уул толгод намссаар ургамлан нөмрөг Дорнод Монголын жинхэнэ хуурай хээрт шилжиж буйг илтгэнэ. Судалгааны талбайд хялганаас (*Stipa sibirica*, *S. baicalensis*), Сибирь зүр өвс (*Filifolium sibiricum*), Саман Ерхөг (*Agropyron cristatum*), Хялгасан Дэвхэргэнэ (*Arenaria capillaris*), Адамсын Шарилж (*Artemisia adamsii*), Ишгэн Шарилж (*Artemisia dracunculus*), Өлчир Шарилж (*Artemisa frigida*), Судалгүй Согоовор (*Bromus inermis*), Ширэг Улалж (*Carex duruscula*), Хөвөн оройт (*Chamaenerion angustifolium*), Цэх Түмэнтана (*Chamaerhodos erecta*), Цагаан Лууль (*Chenopodium album*), Завадскийн Тунхуу (*Dendranthema zavadskii*), Дэвээн Хазааргана (*Cleistogenes squarrosa*), Бүхэлнавчит Багадай (*Dontostemon integrifolius*), Өмхий Шимэлдэг (*Dracoscephalum foetidum*), Нангиад Хиаг (*Elymus chinensis*), Сибирь Хиаг (*Elymus sibiricus*), Жинхэнэ Өрөмтүүл (*Galium verum*), Алтайн Согсоолж (*Heteropappus altaicus*), Томцэцэгт Дурваа (*Koeleria macrantha*), Булцуут Туйпланцар (*Phlomis tuberosa*), Ишгүй Гичгэнэ (*Potentilla acaulis*), Маралнавчит Гичгэнэ (*Potentilla tanacetifolia*) Бургаснавчит Банздоо (*Saussurea salicifolia*), Нарийннавчит Халгай (*Urtica angustifolia*), эмийн сөд (*sanguisorba officinalis*), хөх яргуй (*Pulsatilla turczaninovii*, *P. flavescens*), Одой Сараана (*Lilium pumilum*), Ацан Цахилдаг (*Iris dichotoma*), Удвал навчит тавилгана (*Spiraea aquilegifolia*), Бага алтанзул (*Heimerocallis minor*), Хавтагнавчит Хус (*Betula platyphylla*) гэх мэт зүйлүүд хээрийн судалгааны үед түгээмэл тохиолдож байв.


Ургамлан бүлгэмдэл: Төслийн талбайд д.т.д 962 -1112 м-т өргөгдсөн бэсрэг нам уулсын энгэр, бэл хажуу, хөндий, нарийн ам дагаж сөөг – үетэн – алаг өвст бүлгэмдэл, хиаг – алаг өвс – улалжит татмын нугын ургамлан бүлгэмдэл, алаг өвс - сөөгт хусан ой, үетэн - алаг өвс зүр өвст нугажуу хээр, үетэн-алаг өвс-хялганат уулын хээрийн ургамлан бүлгэмдлүүд тус тус тархан ургаж байна. Төслийн талбайн ургамлан бүлгэмдлийг доорх зургаар үзүүлэв.



Зураг 21. Төслийн талбайн ургамлан бүлгэмдэл

1.6. НИЙГЭМ-ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВ БАЙДЛЫН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

“Шинь Шинь” ХХК-ийн “Улааны холимог металлын ордыг далд уурхайн аргаар ашиглах” төсөл нь Дорнод аймгийн Дашбалбар сумын нутаг дэвсгэрт хэрэгжих бөгөөд Дашбалбар сум нь Монгол орны зүүн хойд хязгаарт оршдог. Хойд талаараа ОХУ-ын Өвөр Байгалийн хязгаарын Акша, Онон район, бусад талаараа Чулуунхороот, Гурванзагал, Сэргэлэн, Баяндун сумдтай хил залгаа оршдог, 871.3 мянган га дэвсгэр газар нутагтай. Газарзүйн байршлаар Дорнод аймгийн төв Чойбалсан хотоос 194 км, Улаанбаатар хотоос 750 км алсад Улз голын Цагаан дэв хэмээх дэнжид томоохон суурин болон өргөжсөн сум юм.



Зураг 22. Дорнод аймаг

Дорнод аймгийн Дашбалбар сум нь 1925 онд байгуулагдсан. Дашбалбар сум нь 871315 га нутаг давсгэртэй. Үүнээс 856990 га газар нь хадлан бэлчээр, 2880 га нь хот тосгон бусад суурингийн эдэлбэр газар, 1032,7 зам, шугам сүлжээний, 7262 га нь ойн сан, 3150 га нь усан сан бүхий газар юм. Сэвсүүл-Жараахай, Харзат, Чух, Номинт, Улз гэсэн 5 багийн нийт 905 өрхөд 3272 хүн амьдардаг. Хүн амын 90 хувь нь нутгийн уугуул буриад ястан, 10 хувь нь халх болон бусад үндэстэн ястан болно. Сумын төвд 216 өрхөд 791 хүн амьдардаг. Хүн амын тоогоор Дорнод аймгийн 14 сумаас 4-д, газар нутгийн хэмжээгээр 5-д ордог сум юм.


Дорнод аймгийн Дашбалбар сумын дотоодын нийт бүтээгдэхүүн 2018 оны жилийн эцсийн байдлаар 837,735.3 сая төгрөг байсан бол 2019 оны жилийн эцсийн байдлаар 1,020,309.4 сая төгрөг болж өссөн байна.



Эх сурвалж: www.1212.mn

Зураг 23. Дорнод аймгийн дотоодын нийт бүтээгдэхүүн

2021 оны жилийн эцсийн байдлаар Дашбалбар суманд 1011 өрхийн 3590 хүн амьдарч байгаа нь, 2016 оноос 97 өрх, 349 хүнээр, 2019 оноос 79 өрх, 163 хүнээр өссөн байна. Хүн амын тооны 2003-2019 оны үзүүлэлтүүдийг дараах зургаар харуулав.



Эх сурвалж: www.1212.mn

Зураг 24. Хүн ам, өрхийн тоо /Дашбалбар сум/

Дорнод аймгийн Дашбалбар сумын хэмжээнд 2021 оны жилийн эцсийн байдлаар 673 малтай өрх 26364 адуу, 29149 үхэр, 218881 хонь, 85084 ямаа, 569 тэмээ тоолуулсан байна.

1.7. ТӨСЛИЙН ГОЛ БОЛОН БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ

Уул уурхайн үйл ажиллагаанаас үүдэлтэй экосистемийн чухал бүрэлдэхүүн хэсгүүдэд үзүүлсэн сөрөг нөлөөллүүдийн орон зайн давхцалуудыг тодорхойлон гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүдийг үнэлж тогтоон тэдгээрийн нөлөөллийн буурах зай, эрчимшлийг тодорхойллоо.

Уул уурхайн үйл ажиллагаанаас үүдэлтэй сөрөг үр дагавар түүний нөлөөллийн буурах зай, эрчимшлийг тогтооход хээрийн судалгаа шинжилгээ, хэмжилтийн дүн болон зөвлөх судлаачдын туршлагаар тодорхойлж газарзүйн мэдээллийн систем дээр тулгуурласан “Нөлөөлөл орон зайд буурах функц” – ыг ашиглан зураглалаа.

Нөлөөлөл орон зайд буурах (F_i) функц

$$F_i = \left(1 / \left(1 + \text{Exp} \left(\left(\left(\text{Distance} / 100 \right) - a \right) * b \right) \right) \right) * \text{Weight}$$

Үүнд:

Distance - нөлөөлөл буурах зай,

Weight - нөлөөллийн эрчим

a, b - налууугийн хүчин зүйлс

Нөлөөлөл буурах зай болон нөлөөллийн эрчим зэрэг нь нөлөөллийн төрөл, газар орны нөхцөл байдлаас шалтгаалан өөр өөр байх тул нөлөөлөл буурах зэрэгтэй уялдуулан налууугийн хүчин зүйлсийг сонгож нөлөөлөл буурах функцийг тогтооно.

Төсөл нь хэрэгжиж эхлээгүй байгаагаас төслийн үйл ажиллагаа явуулах талбайд хийсэн хээрийн судалгааны үр дүнд үндэслэн тооцоолол хийх боломжгүй байсан тул тооцоолол хийхдээ эх үүсвэрээс шалтгаалсан нөлөөллүүдийг дараахи Олон улсын The Nature Conservancy байгууллагын Монгол орны хэмжээнд хийсэн Экологийн бүс нутгийн үнэлгээний тайланд тулгуурлан бүтээсэн MDT /Mongolian Offset Design/ буюу Нөлөөлөл бууруулах загвар програм ашиглан тооцлоо.

НБЗП-Десктоп нь үндсэн дөрвөн багц програмтай:

1. Land Disturbance and Impact Tools-Нөлөөллийн эх үүсвэр болон Нөлөөллийн програм
2. Offset Tools- Дүйцүүлэн хамгааллын програм,
3. Supplementary Avoidance Tools-Нэмэлт Зайлсхийх програм,
4. Update Tools-Шинэчлэх програм.

Нөлөөллийн эх үүсвэр болон нөлөөллийн програм нь хөгжлийн нөлөөллийн мэдээллийн багцыг үүсгэхэд хэрэглэгдэх Нөлөөллийн эх үүсвэрийн мэдээлэл буюу атрибут мэдээлэл, тусгаг гэх зэрэг стандартыг дагаж мөрдөхөд нь хэрэглэгчдэд тусалдаг програм юм.

Дүйцүүлэн хамгааллын програм нь нөлөөллийн өгөгдлийн багцыг ашиглаж дүйцүүлэн хамгааллын зардлын тайлан гаргаж дүйцүүлэн хамгаалах шаардлагатай газрыг тогтоодог.

Нэмэлт зайлсхийх програм нь уул уурхайн болон төлөвлөсөн нөлөөллийн эх үүсвэр ба лицензтэй талбайнуудын хувьд дүйцүүлэн хамгааллын зардлыг тооцон харьцуулах боломжийг хэрэглэгчдэд олгодог. Эдгээр програмын тусламжтайгаар хэрэглэгч дүйцүүлэн хамгааллын зардлаа бууруулахаас гадна Экологийн бүс нутгийн үнэлгээгээр чухал гэж ангилсан ландшафтад хөгжлийг төлөвлөхөөс зайлсхийж болно.

Шинэчлэх програм нь хэрэглэгчдэд НБЗП-г дахин суулгалгүйгээр энэхүү програмын сүүлийн мэдээллийн санг татаж авахад тусалдаг.


Дээрхи программд нөлөөллийн эх үүсвэрүүдийг дараахи байдлаар эх мэдээлэл болгон оруулж үр дүнг гарган авав.

Хүснэгт 3. Нөлөөллийн эх үүсвэр

№	Нөлөөллийн эх үүсвэр	Нөлөөллийн эх үүсвэрийн код
Шугаман эх үүсвэр		
1	Хүдэр тээврийн зам	6
2	Эргэлтийн усны шугам	4
3	Хаягдал булинга дамжуулах хоолой	4
4	Цэвэр усны шугам	4
5	Бохир усны шугам	4
6	Цахилгаан дамжуулах шугам	1
7	Далд уурхайн ус татах шугам	4
8	Буцах усны хоолой	4
Талбайн эх үүсвэр		
1	Авто пүү	18
2	Агуулах	8
3	Ажилчдын амрах байр	4
4	Гаалийн хяналтын талбай	14
5	Граж	6
6	Дүүргэлтийн байгууламж	7
7	Дэд станц	18
8	Засварын газар	7
9	Зочид буудал	4
10	Монгол хоолны заал	4
11	Насос станц	18
12	Нүүрс буулгах талбай	8
13	Оффис	6
14	Сорьцын лаборатори	6
15	Усан оргилуур	18
16	Уурын зуух	7
17	Халуун усны байр	4
18	Харуулын байр	18
19	Химийн бодисын агуулах	8

№	Нөлөөллийн эх үүсвэр	Нөлөөллийн эх үүсвэрийн код
20	Хүчилтөрөгчийн станц	7
21	Хятад хоолны заал	4
22	Цэвэрлэх байгууламж	7
23	Шохойн агуулах	8
24	Шохойн цех	7
25	ШТС	9
26	Эмнэлэг, хангамжийн оффис	6
27	Хаягдлын сан	19
28	Баяжуулах үйлдвэр	7
29	Далд уурхайн амнууд	10
30	Хүдрийн овоолго	12
31	Шимт хөрсний овоолго	12
32	Явган хүний зам, талбай	14
33	Автомашины зогсоол	14
34	Эргэлтийн усан сан	13
35	Усан сан	13
36	Далан	12
37	Эргэлтийн усны станц	18
38	Тоглоомын талбай	18
39	Цугларах талбай	18
40	Тэсрэх бодисын агуулах	8

Төслийн үйл ажиллагаа явагдаж байгаа нутаг дээр дурдсан нөлөөллийн функцуудыг ашиглан гол болон болзошгүй нөлөөллийн нэгдсэн зураглалыг гарган нөлөөлөлд өртөх газрын талбайн хэмжээг тооцов.



Зураг 25. Нөлөөллийн эрчимшлийн ангилал, өртөх талбайн хэмжээ

Хүснэгт 4. Нөлөөлөлд өртөж буй газрын хэмжээ

№	Нөлөөллийн эрчим	Талбай /га/
1	Их	229.41
2	Дунд	100.69
3	Бага	366.64
НИЙТ		696.74

Дээрх хүснэгтээс дүгнэж үзэхэд төслийн үйл ажиллагааны хүрээнд нөлөөлөлд өртөх талбай нь 696.74 га буюу үүнээс нөлөөллийн их ангилалд 229.41 га, дунд ангилалд 100.69 га, бага ангилалд 366.64 га талбайг тус тус эзэлж байна.

Нөлөөллийн бүсийн хувьд 12.62% нь Дорнод аймгийн Баяндун суманд, 87.38 % нь Дорнод аймгийн Дашбалбар суманд хамаарагдаж байна.

Нөлөөлд өртөх газар нь экосистемийн хувьд дараах төрлүүдийг агуулсан байна.

Хүснэгт 5. Нөлөөлөлд өртөх экосистемүүд

№	Экосистемийн төрөл	Нөлөөлд өртөх талбай /га/
1	Нугажуу хээр /meadow steppe/	696.74

1.8. НӨЛӨӨЛИЙН ХЭЛБЭР, ҮРГЭЛЖЛЭХ ХУГАЦАА

Нөлөөллийн хэлбэр, шууд, шууд бус эсэх, дараалал, буцалттай, буцалтгүй эсэх, хугацаа зэргийг магадлан жагсаах аргыг (checlist) ашиглан тодорхойлов. Р.Мижиддорж байгаль орчны төлөв байдлын үнэлгээнд магадлан жагсаах аргыг ашиглах 2 хувилбарыг нэгтгэсэн байдлаар боловсруулсан байдаг /Р.Мижиддорж, 2002 он/. Үүнд:

Экосистемийн бүрэлдэхүүн хэсгүүдэд нөлөөлөх байдал: Энд экосистемийн өөрчлөлт, байгалийн нөөцийн ашиглалт, орчны чанарын өөрчлөлт, байгалийн өнгө төрх, түүх соёлын дурсгалт зүйл, археологи, палентологийн олдвор, эдийн засаг, нийгмийн асуудал, бусад асуудал гэсэн хэсэгт хамаарах нөлөөллийн хэлбэр (шууд, шууд бус), хугацаа (богино болон урт хугацааны) харуулсан магадлах жагсаалтыг нэрлэж болно.

Төслийн байршил, шийдэлтэй холбоотой нөлөөллийн магадлах жагсаалт: Төслийн байршил, уг төслийн шийдэл, төлөвлөгөөтэй холбоотой нөлөөлөл, мөн барилга байгууламж барих, үйлдвэрлэлийн аюулгүй ажиллагаатай холбоотой байгаль орчны асуудал, төслийг ерөнхийд нь хянаж үзэх шалгуур буюу бодлогын чанартай асуудалд хамаарах үйлдвэр аж ахуйн газрын нөлөөллийн эрчмийг заах явдал юм.

1.9. ЭКОСИСТЕМИЙН БҮРЭЛДЭХҮҮН ХЭСГҮҮДЭД НӨЛӨӨЛӨХ БАЙДАЛ

Экосистемийн өөрчлөлт: Төсөл хэрэгжих газрын талбайд д.т.д 962-1112 м-т өргөгдсөн бэсрэг уулсын энгэр, бэл хажуу, хөндийгөөр үетэн-алаг өвст хусан ой, алаг өвс-улалж-үетэнт ойн нугын, үетэн-алаг өвс-зүр өвст уулын хээрийн, тал хөндийн алаг өвс-үетэн-хиагт бүлгэмдэл тус тус тархаж байна. Эдгээр ургамлан бүлгэмдэл уурхайн олборлолтын үйл ажиллагаанд өртөж устах бөгөөд нөлөөллийн хэлбэр шууд, нөхөн сэргээх хугацаа хээрийн бүсэд дунджаар 7 жил [С.Оюунсүвд, Ж.Ундармаа, Экологийн судалгааны төв], олборлолт баяжуулалт, гадаад, дотоод тээвэрлэлт болон бусад барилга байгууламжид бүрэн устах учир нөлөөллийн эрчим хүчтэй ангилалд хамаарна.

Хээрийн судалгааны үр дүнгээр, амьтан судлаачдын бүтээлд тэмдэглэсэн зүйл, өмнө хийгдсэн судалгааны дүнг нэгтгэн тус нутагт 234 зүйл шавьж, 2 зүйл хоёр нутагтан, 3 зүйл мөлхөгч, 23 зүйл шувуу, 18 зүйл хөхтөн амьтан тэмдэглэгдсэн байна. Энэ нутагт ойт хээрийн бүсэд дасан зохицсон амьтад амьдарч байгаа ба зөвхөн энэ бүс нутагт амьдардаг дагуур зараа, дагуур номин болон дагуур огдой зэрэг дагуурын элемент тохиолдоно. Уулсын ам хөндийгөөр амьдрах орчин хооронд шилжих бөгөөд амьдрах орчин, амьтдын замналд өөрчлөлт орно. Энэ нөлөөлөл нь шууд, богино хугацааны /төслийн үйл ажиллагаа зогссоноос 2 жилийн дотор амьтдын шилжилт хэвийн горимд шилжинэ/ эсвэл урт хугацааны /амьдрах орчны нөхөн сэргээх хугацаа доод тал нь 7 жил/, дунд зэрэг нөлөөлөлд хамаарна. Гадаргын хэлбэршил өөрчлөгдөх хэдий ч бүсийн бичил уур амьсгалд үзүүлэх нөлөөлөл харьцангуй бага юм.

Ландшафт, геологийн тогтоц: Уурхайн орд газар нь нам уулс, ухаа гүвээ, толгодоор хүрээлэгдсэн, толгодын орой хяр нь бөөрөнхий хавтгайдуу оройтой, уулын ар хажуу нь нилээд огцом, эдгээрийн хооронд нарийвтар хөндийнүүдтэй байна. Эдгээр хөндийд нимгэн зузаан янз бүрийн давхаргатай хар хүрэн хөрсний хэв шинжүүд делювийн нунтаг карбонатлаг хурдас дээр үүссэн байна. Харин ухаа толгодын хөрс үүсгэгч эх чулуулаг нь элювийн байнгын хатуу чулуулаг, элюви-делювийн нунтаг карбонатлаг хурдастай байна. Уурхайн эзэмшил талбай орчимд сийрэг хусан ой бүхий ойт хээр, хээрийн үндсэн 4 хэв шинжийн хөрс зонхилон тархсан байна. Үүнд:

- Ойн бараан (нимгэн)-Хусан ой бүхий газарт
- Чулуурхаг Хархүрэн (толгодын хар хүрэн)-Уулын орой энгэр газарт
- Ердийн Хархүрэн (тал хөндийн хар хүрэн)-Бэл хормойн тэгшивтэр газарт
- Нугархаг Хархүрэн-Ар хажуу, хөндий судаг газарт

Мөн эдгээр хөрснөөс гадна ус чийг ихтэй судаг дагууд Глейрхэг дарагдмал үетэй хөрс бага хэмжээгээр тархана. Эдгээр хэв шинжийн хөрс олборлолт, баяжуулалт, дотоод, гадаад тээвэрлэлт болон бусад объектуудын нөлөөгөөр элэгдэл, эврдэл орно. Энэ нөлөөлөл нь шууд, урт хугацааны, хүчтэй нөлөөлөлд хамаарна. Хүдрийн овоолго, хоосон чулуулгийн овоолго зэрэг нь 5-10 м, бутлуурын цех, баяжуулах үйлдвэр, химийн бодисын агуулах, баяжмалын агуулах зэрэг барилга байгууламж нь 2-5 давхар өндөртэй байна. Өөрөөр хэлбэл ийм өндөр хэлбэршил бүхий техноген объектоор уулын хажуу, бэл, хормой, уулс хоорондын

нарийхан ам хөндий солигдоно. Энэ нөлөөлөл нь шууд, богино хугацааны / төсөл хэрэгжиж дууссаны дараа барилга байгууламжийг хураана, хоосон чулуулгын овоолго, хаягдлын овоолго зэргийг нөхөн сэргээнэ. Иймд төсөл хэрэгжиж дууссаны дараа 2 жилийн хугацаанд хуучин хэв шинжиндээ орох боломжтой/, дунд зэргийн эрчимтэй байна.

Улааны холимог металлын орд нь Төв-Монголын атираат системийн зүүн хойд талын Хойд-Чойбалсан хүдрийн районд байрладаг. Хойд-Чойбалсан район нь Хойд-Хэрлэнгийн геоантиклиналь өргөгдөлд холбогдон, хожуу протерозойн үед дундад массивт хөгжсөн бөгөөд Дорнодын галт уулын тектоник структурын Улааны блокын зүүн хойд захын хэсэгт байрлана. Ордын талбай нь ойролцоогоор 0.5 км², баруун хойш суналтай Мухар ба Зүүн Мухарын хагарлуудын хоорондох блокт зүүн урд талаас 1 км сунаж хөгжсөн хүдэр агуулсан дэлбэрэлтийн хоолойг агуулна. Районы мезозойн өмнөх үүслүүдэд протерозойн тунамал, галт уулын гаралтай чулуулаг, палеозойн амфиболит ба ногоон занарын фаациуд багтаж хувиралд орсон төрөл бүрийн магматитууд, гранит-гнейс, гранодиорит давамгайлсан гранитоид, түрүү ба хожуу палеозойн гранитууд төлөөлдөг. Далд уурхайн малталт нэвтрэлтээр нийт 6302886.5 м³ хурдас чулуулаг өртөгдөнө. Үүнээс геологийн тогтоцод үзүүлэх нөлөөлөл нь шууд, урт хугацааны, хүчтэй нөлөөлөл юм.

Байгалийн нөөц ашиглалт: Төслийн үйл ажиллагаа нь өөрөө Улааны холимог металлын ордыг ашиглах юм. Иймд эрдэс баялгийн нөөцийг буцалтгүй шинжтэй шууд олборлох бөгөөд урт хугацааны, хүчтэй нөлөөлөл юм. Мөн усны нөөцийг олборлолтын болон баяжуулалтын үйл ажиллагаанд ус ашиглана. Усны нөөцийг төслийн үйл ажиллагаанд шууд ашиглах боловч усны нөөцийн ашиглалт нь газрын доорх усны боломжит нөөц буюу нөхөн сэргэх нөөцийг ашиглаж байгаа учир богино хугацааны, дунд зэрэг нөлөөлөл юм. Төслийн үйл ажиллагаанаас 102 га талбайн бэлчээрийн нөөц өртөгдөнө. Энэ нь шууд, урт хугацааны, хүчтэй нөлөөлөл юм. Дулаан хангамжид нүүрс ашиглана. Адуун чулууны нүүрсний ордын олборлосон нүүрсийг ашиглах бөгөөд олборлосон нүүрсийг ашиглаж байгаа учир шууд бус, урт хугацааны, хүчтэй нөлөөлөл юм.

Байгаль орчны чанарын өөрчлөлт: Орчны чанарт өөрчлөлт оруулах боломжтой төслийн эх үүсвэрийг технологийн бүх үе шаттай уялдуулан авч үзэв. Үүнд:

Олборлолтын үйл ажиллагаа: Далд аргаар олборлолт явуулна. Иймд олборлолтын үеийн малталт, нэвтрэлтээс гадаад орчны агаарын чанарт сөрөг нөлөөлөл үзүүлэхгүй. Харин далд уурхайн дотоод орчны агаарт их хэмжээний тоосонцор тэсэлгээний үед үүснэ. Ордын ТЭЗҮ-д тэсэлгээний үеийн тоосжилтыг усан манан үүсгэгчээр бууруулахаар тусгасан байна. Дотоод орчны агаарын чанарын өөрчлөлт нь далд уурхайн газар доор ажиллах ажилчдын эрүүл мэндэд сөрөг нөлөөлөл үзүүлнэ. Энэ нөлөөллийн эрчим нь дунд зэрэг, дунд хугацааны, шууд нөлөөлөл юм.

Олборлосон хүдрийг хүдрийн түр овоолго хүртэл тээвэрлэх үед агаарт тоосжилт үүснэ. Налуу гол ам болон босоо гол амаар газрын гадаргуу дээр гарч ирсэн хүдэр болон хоосон чулуулгийг ачих үед тоосжилт үүсэх боломжтой юм. Суурь чулуулаг, хөрсөн агуулагдах хүнд металлууд тухайн орон нутгийн геологийн тогтоцоос хамаарч хүлцэх агууламжаас өндөр гарч байна.

Баяжуулах үйл ажиллагаа: Хүдрийн бункерт хүдэр буулгах үед тоосжилт үүснэ. Эндээс үүсэх тоос нь 120 сек хугацаанд газар бууж түүнээс хойш агаар дахь агууламж нь буурна. Иймд богино хугацааны нөлөөлөлд хамаарах бөгөөд шууд нөлөөлөл юм. Нөлөөллийн эрчим нь дунд зэрэг юм. Бутлах, нунтаглах үед мөн тоосжилт үүснэ. Бутлах талбайгаас Dust Trak 8530 багажаар газар дээр нь хэмжсэн дүнгээр жижиг ширхэгт тоосонцорын агууламж 0.4 мгр/м^3 байна. Агаарын чанар Техникийн ерөнхий шаардлага (MNS 4585;2007) стандартын 24 цагийн жижиг ширхэгт тоосонцрын стандарттай (50 мкг/м^3) харьцуулахад 8 дахин их байна. Иймд энэ нөлөөллийн эрчим хүчтэй, богино хугацааны (хурдан сарнина) шууд нөлөөлөл юм. Үндсэн, хяналтын, цэвэрлэгээний флотаци нь тус бүр 16 м^3 багтаамж бүхий флотамашинд явагдах бөгөөд эндээс агаарын чанарт үзүүлэх сөрөг нөлөөлөл бага. Харин флотациас гарах хаягдал нь хаягдлын санд хуримтлагдах бөгөөд энэ нь орчны хөрс, усны чанарт сөрөг нөлөөлөл үзүүлнэ. Усны чанарт үзүүлэх нөлөөлөл нь шууд бус (баяжуулалтаас хаягдлын санд хуримтлагдана. Хаягдлын сангаас шүүрэх, хаягдлын сан сэтрэх үед нэвчиж хөрс, усны бохирдол үүсгэх эрсдэлтэй), урт хугацааны, эрчим нь хүчтэй нөлөөлөл байна.

Байгалийн өнгө төрх, түүх соёлын дурсгалт зүйл, археологи, палентологийн олдвор: Олборлолтын үеийн хурдас чулуулгийн овоолго, хүдрийн түр овоолго, баяжуулах үйлдвэрийн барилга, байгууламж зэрэг нь орчны гадаргын хэлбэршил, өнгө төрхийг бүрэн өөрчилнө. Иймд энэ нөлөөллийн эрчим их, дунд хугацааны шууд нөлөөлөлд хамаарна. Төслийн талбай орчим улсын болон орон нутгийн тусгай хамгаалалттай газар нутаг байхгүй юм. Палеонтологийн хайгуул судалгааны ажлын үр дүнгээр төслийн талбайд эртний амьтан ургамлын олдвор олногүй. Мөн түүх соёлын дурсгал илрээгүй байна.

1.10. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГОЛ ЗОРИЛТ, ХАМРАХ ХҮРЭЭ

“Шинь Шинь” ХХК-ийн “Улааны холимог металлын ордыг далд уурхайн аргаар ашиглах” төслийн БОННУ-ний ажлыг Монгол Улсын Байгаль хамгаалах тухай хууль, Газрын хэвлийн тухай хууль болон “Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай” хуульд заасны дагуу болон Байгаль орчны үнэлгээний тайлан хийх аргачлалын дагуу хийж төслийн хэрэгжилтийн явцад авч хэрэгжүүлэх байгаль орчны менежментийн төлөвлөгөөг боловсруулав.

Энэхүү байгаль орчны менежментийн төлөвлөгөө нь төслийн байгаль орчинд учруулж болзошгүй сөрөг нөлөөллийг төслийн технологи ажиллагааны онцлогтой нь уялдуулан олон улсын хэмжээнд хүлээн зөвшөөрөгдсөн гол болон болзошгүй нөлөөллийг тодорхойлох арга, аргачлалын дагуу байгаль орчны бүрэлдэхүүн хэсгүүдийг тус бүрд нь авч үзсэний үндсэн дээр байгаль орчныг хамгаалах бусад багц хууль, холбогдох журам, зааврын дагуу хийж гүйцэтгэсэн болно.

Байгаль орчныг хамгаалах менежментийн төлөвлөгөө нь байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх талаар Монгол Улсын хуулиуд, шинээр гарч буй шаардлагатай уялдан байнга шинэчлэгдэж байх баримт бичиг төдийгүй төслийн хэрэгжилтийн үе шатанд байгаль хамгаалах, болзошгүй сөрөг нөлөөллийг тухай бүр нь бууруулж нөхөн сэргээх зорилтыг хангах үүрэгтэй юм.

2. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

2.1. АГААР ОРЧИНД ҮЗҮҮЛЭХ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ ЧИГЛЭЛЭЭР

2.1.1. Төсөлд хэрэглэгдэж буй тээврийн хэрэгслүүдэд Монгол улсад мөрдөгдөж буй утааны ба бохирдлын стандарт шаардлагын дагуу техникийн хяналтын үзлэгт 2024 оны 03-р сарын 23-нд нийт 49 авто тээврийн хэрэгслийг хамруулсан.

2.1.2. Хатуу хучилтгүй зам дээрх тээврийн хөдөлгөөнөөс үүсэх тоосжилтыг бууруулахаар дулааны улиралд усны машинаар услах, замыг дагтаршуулах ажлыг зохион байгуулж байна. Усалгааг хуваарийн дагуу, бүртгэлийн дэвтэрт бүртгэн гүйцэтгэж байна. Усалгааг хур тунадас орж зам талбайн тоосжилт буурсан үед усалгааг өнжиж, зам талбайн тоосжилт ихтэй өдрүүдэд тасралтгүй хийж гүйцэтгэсэн. Энэ онд 102 удаагийн усалгаа хийгдсэн байна.

2.1.3. Хүдрийг түр овоолгод ачиж буулгах талбайд тоосжилт үүсэх сөрөг нөлөөллийг бууруулах зорилгоор чулуу болон хаягдал дугуйн хаалтны бүрэн бүтэн байдалд 7 хоног тутамд хяналт тавьдаг. Эвдэрч, нурсан тохиолдолд тухай бүр нь засварлуулж байна.

2.1.4. Хаягдлын сангийн тоосжилтыг бууруулах усалгааг энэ онд хаягдлын сангийн далан өндөрлөх төлөвлөгөөт ажил хийгдсэнээс бусад үед тогтмол хийж, бүртгэлийн дэвтэрт бүртгэн гүйцэтгэсэн.

2.2. ГАДАРГЫН БОЛОН ГАЗРЫН ДООРХИ УСАНД ҮЗҮҮЛЭХ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ ЧИГЛЭЛЭЭР

2.2.1. 2024 оны усны хэрэглээ, ашиглалт

Усны эх үүсвэр, усны нөөц, ус ашиглалтын хууль эрх зүйн орчин

Улааны холимог металлын уурхайн ус хангамжид зориулсан ус татах талбайд газрын доорх усны ашиглалтын нөөцийг баталгаажуулах мөн Монгол Улсын Засгийн газрын 2014 оны 12 дугаар тогтоолоор “Улсын төсвийн хөрөнгөөр судалж тогтоосон газрын доорх усны нөөцийн эрэл, хайгуул судалгааны зардлыг ус ашиглагчаар эргүүлэн төлүүлэх журам”-ын дагуу Сэвсүүлийн голын Ногоон бүрдийн талд 2014-2015 онд усны судалгааны ажлыг хийж гүйцэтгүүлсэн.

Улааны уурхайн баяжуулах үйлдвэрт шаардагдах боломжит нөөцийн дүгнэлтийг 2015 оны 09 сарын 28-ны 08/5819 тоот Байгаль Орчин, Ногоон Хөгжлийн Яамаар гаргуулж мөн 2015 оны 08 дугаар сарын 20-ны 08/6039 тоот ордын нөхөн төлбөрийн дүгнэлт гаргуулсан. Уг дүгнэлтийн дагуу Монгол-Ус ТӨҮГазартай 5 жилийн хугацаатай гэрээ байгуулан улсын төсвийн хөрөнгөөр судалж тогтоосон газрын доорх усны нөөцийн эрэл, хайгуул судалгааны зардлыг төлж дууссан. Гүний хоолойн ус татах байгууламж нь 9 худаг, 2 ус өргөх станц, нэг бүр 300, 300, 500, 900, 1500, 1500 шоо метр багтаамжтай 6 ширхэг ус хуримтлуулах сантай. Цэвэр ус дамжуулах шугам хоолой 7000м урттай Ш500 PVC хоолой 11000м урттай Ш500 ган хоолой нийт 18000 м хоолойгоор цэвэр ус дамжуулдаг.



Зураг 26. Усны эх үүсвэрүүд

Улааны уурхайн усны хэрэгцээнд нийт гүний 9 худгийг унд ахуй, баяжуулах үйлдвэр, дүүргэлтийн цех, уурын зуух-дулаан үйлдвэрлэх, ногоон байгууламжийн хэрэгцээнд ашигладаг. Усны тухай хуулийн 28.4, 28.6, 28.7, 29.1-т тус тус заасны дагуу, Усны газрын 2024 оны 04 сарын 22-ны өдрийн 50 дугаартай ус ашиглуулах дүгнэлт, Онон-Улз голын сав газрын захиргаанаас олгосон 2024 оны 05-р сарын 07-ны №А/02 дугаартай ус ашиглах зөвшөөрлийг үндэслэн Онон-Улз голын сав газрын захиргаатай 2024 оны 05 дугаар сарын 07-ны өдрийн 01 дугаартай ус ашиглуулах гэрээг нэг жилийн хугацаатайгаар байгуулсан.

“Усны нөөц ашигласны төлбөрийн хувь хэмжээг тогтоох, хөнгөлөх тухай” Монгол Улсын Засгийн газрын 2013 оны 09 дүгээр сарын 21-ний өдрийн 326 тоот тогтоол, Засгийн газрын 2011 оны 10 дугаар сарын 26-ны өдрийн 302 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтаар баталсан “Ашиглалтын зориулалтыг тооцох итгэлцүүр”-т өөрчлөлт оруулах тухай 2013 оны 09 дүгээр сарын 21-ний өдрийн 327 дугаар тогтоолуудыг тус тус үндэслэн ус ашиглалтын төлбөрийг тооцож барагдуулсан. Эдгээр тогтоолуудын дагуу ус ашиглах зориулалтыг дараах байдлаар ангилдаг бөгөөд ноогдох төлбөрийн хувь хэмжээ өөр өөр байна.

Хүснэгт 6. Ус ашиглах зориулалт, усны төлбөрийн хувь хэмжээ

Төлбөр ноогдох ус		Төлбөрийн хувь /Экологи эдийн засгийн үнэлгээний хувиар /	Ашиглалтын зориулалтыг тооцох итгэлцүүр	Ноогдох усны төлбөр м3 /төг
1	Баяжуулах үйлдвэр	35	1.4	1362.2
2	Далд уурхайн шавхалтын ус	15	1.2	500.4
3	Унд-ахуйн хэрэгцээнд			1500
4	Тоосжилтын эсрэг зам талбайн усалгаа			166.8
5	Ногоон байгууламжийн усалгаа	10	0.25	69.5
6	Уурын зуух-дулаан үйлдвэрлэл	15	0.15	62.55

Ус ашигласны төлбөрийн хэмжээг усны эх үүсвэр дээр (худагт) байрлуулсан усны тоолуурын заалтын зөрүүг үндэслэн баталгаажуулж, тухайн сарын 24-ний өдөр Дашбалбар сумын байгаль хамгаалагчид хянуулдаг.

Төслийн хэмжээнд ашиглаж буй худгуудад хэмжил зүйн баталгаажуулалт бүхий усны тоолуурыг суурилуулан ашиглаж байна. Усны тоолуурын баталгаажуулалт хийсэн талаар дэлгэрэнгүй мэдээллийг хүснэгт 7-д үзүүлэв.

Хүснэгт 7. Усны тоолуурын баталгаажуулалт хийсэн дэлгэрэнгүй мэдээлэл

Тоолуурын байршил	Марк, серийн дугаар	Диаметр	Тоолуур үйлдвэрлэгч	Баталгаажуулалт хийсэн огноо	Дуусах хугацаа	Ашиглалтын зориулалт
Худаг 1	1609027998	150	БНХАУ	2023.11.29	2025.11.29	Мөнгөн тооцоо
Худаг 2	202300907	150	БНХАУ	2024.03.18	2025.03.18	Мөнгөн тооцоо
Худаг 3	1704000033	150	БНХАУ	2023.11.29	2025.11.29	Мөнгөн тооцоо
Худаг 4	2406022238	150	БНХАУ	2024.07.29	2026.07.29	Мөнгөн тооцоо
Худаг 5	2406022240	150	БНХАУ	2024.07.29	2025.07.29	Мөнгөн тооцоо
Худаг 6	202300911	150	БНХАУ	2024.04.26	2026.04.26	Мөнгөн тооцоо
Худаг 7	202300912	150	БНХАУ	2024.04.26	2026.04.26	Мөнгөн тооцоо
Худаг 8	03190006	150	БНХАУ	2024.04.26	2026.04.26	Мөнгөн тооцоо
Худаг 9	202300910	150	БНХАУ	2024.04.26	2026.04.26	Мөнгөн тооцоо
Далд уурхайн шавхалтын шугам гадна	2406022211	100	БНХАУ	2024.07.29	2026.07.29	Мөнгөн тооцоо
Далд уурхайн шавхалтын шугам дотор	18030181	100	БНХАУ	2023.03.27	2025.03.27	Мөнгөн тооцоо
БУСангийн насос	2104000659	80	БНХАУ	2023.11.13	2025.11.13	Мөнгөн тооцоо
Ахуйн бохир ус цэвэрлэх байгууламж	2107000804	65	БНХАУ	2023.11.13	2025.11.13	Дотоод хяналт хэрэглээг хянах
Дүүргэлт цех	2406022202	100	БНХАУ	2023.11.13	2025.11.13	Дотоод хяналт хэрэглээг хянах

2.2.2. 2024 оны ус ашиглалт, төлбөр тооцоо

Баяжуулах үйлдвэр уурхайн үйл ажиллагааны төлөвлөгөөний дагуу ажиллаж, 2024 оны 10 дугаар сарын байдлаар 394,610.75 шоо.метр усыг технологийн хэрэгцээнд нөхөн сэлбэлтээр авч ашигласан. График 1-т технологийн хэрэгцээнд нөхөн сэлбэлтээр ашигласан усны хэрэглээг сар бүрээр харуулав.




График 1. Улааны орд төслийн нөхөн сэлбэлтээр ашигласан ус

Хүснэгт 8. Улааны орд төслийн нөхөн сэлбэлтээр ашигласан усны нийт хэмжээг хэрэглээний төрлөөр (ашиглалтын худгуудын баталгаат усны тоолуурын заалтаар тооцсон)

Зориулалт	Ашигласан усны хэмжээ шоо/метр	Тайлбар
Баяжуулах үйлдвэрийн усны эх үүсвэрээс	394,610.75	Баяжуулах үйлдвэрт нөхөн сэлбэлтээр ашигласан усны хэмжээ
Унд-ахуйн	36,000	Унд ахуйд ашигласан ус
Далд уурхайн шавхалтын ус	106,188.5	Стандарт хэмжилзүйн баталгаажсан тоолуураар тооцов. Усыг баяжуулах үйлдвэрт ашигласан.
Ногоон байгууламжийн усалгаа	30,168.45	
Уурын зуух-Дулаан үйлдвэрлэл	3000	
Ахуйн бохир цэвэрлэх байгууламж	24,945	
Тоосжилтын эсрэг зам талбайн усалгаа	1,470	
Нийт	596,382.7	

2023 оны 12 дугаар сарын 24-с 2024 оны 10 дугаар сарын 24-ний өдрийн байдлаар төслийн хэмжээнд ус ашигласны нийт төлбөр 647,205,042.73 (зургаан зуун дөчин долоон сая хоёр зуун таван мянга дөчин хоёр төгрөг далан гурван мөнгө) ноогдуулснаас 2024 оны 10 дугаар сарын 24-ний байдлаар 647,205,042.73 (зургаан зуун дөчин долоон сая хоёр зуун таван мянга дөчин хоёр төгрөг далан гурван мөнгө) төгрөгийг Дорнод аймаг болон Дашбалбар сумын төсөвт төлөөд байна.

/2024 оны 10 сарын 24-ний байдлаар ус ашиглалтын дэлгэрэнгүйг график 2-т үзүүлэв./




График 2. Ус ашиглалтын төлбөрийн дүн

Хүснэгт 9. 2024 оны ус ашиглалтын төлбөрийн гүйцэтгэл

2024 он	Төлбөрийн нэхэмжлэл /төг/	Төлбөрийн гүйцэтгэл /төг/	Тайлбар
1-р сар	77,553,426.60	77,553,426.60	Дансаар төлсөн, усны тоолуурын бичилт, төлбөр төлсөн баримтыг хавсралтаар харуулав.
2-р сар	84,128,182.20	84,128,182.20	
3-р сар	75,344,633.20	75,344,633.20	
4-р сар	75,196,092.24	75,196,092.24	
5-р сар	60,633,544.57	60,633,544.57	
6-р сар	42,868,106.78	42,868,106.78	
7-р сар	38,622,991.175	38,622,991.175	
8-р сар	69,674,957.055	69,674,957.055	
9-р сар	59,196,443.31	59,196,443.31	
10-р сар	63,986,665.6	63,986,665.6	
Нийт	647,205,042.73	647,205,042.73	

2024 оны 03-р сарын 22-ны өдөр Олон улсын “Усны өдөр”-ийг тэмдэглэж “Ус ба Энхтайван” буюу “Water and Peace” уриан дор “Цэнхэр тууз” аянд нэгдэн сургалт сурталчилгаа зохион байгуулсан. Ундны усны эрүүл ахуйг хангах, дэлхийн усны өдөр, нүхэн жорлонгоос үүдэлтэй хөрс усны бохирдлыг бууруулах, ус хэмнэх аргууд,

Монгол улсын усны нөөц, компанийн усны тухай мэдээллийг 4 ээлжийн сургалтаар 267 ажилтанд хүргэсэн.



Зураг 27. Дэлхийн усны өдрийг тохиолдуулан зохион байгуулсан сургалт



Зураг 28. Цэнхэр тууз аянд нэгдсэн нь

Ахуйн бохир ус цэвэрлэх байгууламж

Улааны уурхай нь ажилчдын унд ахуйгаас гарсан бохир усыг цэвэршүүлэх ионжуулагч цэвэрлэх байгууламжтай ба бохир усыг септик, бактерийн наалдац бүхий биологийн цэвэрлэгээ, хэт ягаан туяа гэсэн хэсгүүдээр дамжин цэвэрлэдэг. Мембран биореактор (MBR)-ын технологиор хоногт 150м³ ахуйн бохир ус цэвэрлэх хүчин чадалтай.

Усны хяналт шинжилгээний ажлын хүрээнд улиралд хоёроос доошгүй удаа ахуйн бохир ус цэвэрлэх байгууламжийн оролт болон гаралтын хэсгээс дээжлэлт хийж, Дорнод аймгийн Стандарт хэмжил зүйн хэлтсийн итгэмжлэгдсэн сорилтын лаборатори, Усны газрын лабораториудад шинжлүүлдэг. Хүснэгт 10, 11-т 2024 оны 02, 03, 05, 07, 08 болон 10-р саруудын шинжилгээний үр дүнг харуулав.



Зураг 29. Ахуйн бохир усны дээжлэлт

Хүснэгт 10. Ахуйн бохир усны химийн үзүүлэлт

Дээж авсан цэг		Ахуйн бохир ус цэвэрлэх байгууламж оролт					
		2-р сар	3-р сар	5-р сар	7-р сар	8-р сар	9-р сар
Шинжилсэн үзүүлэлт							
Усны орчин	6-9	8.15	8.46	7.23	7.76	7.27	10.71
Умбуур бодис	400	760	105	22.5	103.6	785	156
Биохимийн хэрэгцээт хүчилтөрөгч	400	280.42	155.38	168.4	-	942.55	-
Химийн хэрэгцээт хүчилтөрөгч	800	729.1	404	-	96	2450.65	105.6

Хүснэгт 11. Ахуйн бохир усны химийн үзүүлэлт

Дээж авсан цэг		Ахуйн бохир ус цэвэрлэх байгууламж гаралт					
		2-р сар	3-р сар	5-р сар	7-р сар	8-р сар	9-р сар
Шинжилсэн үзүүлэлт							
Усны орчин	6-9	8.31	8.2	7.17	7.70	8.11	7.92
Умбуур бодис	30	0	13	147	0.6	6	1.6
Биохимийн хэрэгцээт хүчилтөрөгч	20	465.57	20.57	78.6	-	25.11	-
Химийн хэрэгцээт хүчилтөрөгч	50	54.7	84.6	-	48	65.30	57.6

2023 оны 12-р сарын 24-нөөс 2024 оны 10-р сарын 24-ний өдөр хүртэл 24945 шоо/метр усыг баяжуулах үйлдвэрт нийлүүлсэн байна. Стандарт хэмжил зүйн газраар баталгаажуулсан тоолуурын заалтаар тооцов.

Хүснэгт 12. Ахуйн бохир ус цэвэрлэх байгууламжаас эргүүлэн ашигласан ус

№	Огноо	Усны хэмжээ
1	2023.12.24-2024.01.24	2306 шоо/метр
2	2024.01.24-2024.02.24	2193 шоо/метр
3	2024.02.24-2024-03.24	2112 шоо/метр
4	2024.03.24-2024.04.24	3221 шоо/метр
5	2024.04.24-2024.05.24	2494 шоо/метр
6	2024.05.24-2024.06.24	2128 шоо/метр
7	2024.06.24-2024.07.24	2206 шоо/метр
8	2024.07.24-2024.08.24	3016 шоо/метр
9	2024.08.24-2024.09.24	2596 шоо/метр
10	2024.09.24-2024.10.24	2673шоо/метр
	Нийт	24945 шоо/метр

2.2.2.1. Хаягдлын далангийн хяналтын цооногуудын бүрэн бүтэн байдлыг шалгаж, 10 хоног тутам хяналтын цооногийн хэмжилт хийж байна. Нийт 27 удаагийн хэмжилт хийж, 9 цооногийн пайзыг шинэчилж суурилуулсан.

Хаягдлын санд 2022 онд автомат 12 цооног суурилуулсан. Автомат цооног нь хаягдлын далангийн шилжилт хөдөлгөөн, усны түвшин мэдрэх, хаягдлын сангийн усны түвшин тодорхойлдог. Автомат цооног нь сансрын хиймэл дагуулын мэдээллийг ашиглан боловсруулалт хийдэг.

2.2.2.2. Усны эх үүсвэр болох гүний усан сан, 1-р өргөх насосны станц болон 2-р өргөх насосны станцны ажилтнуудад зориулан ус ашиглахгүйгээр органик бохирдлыг боловсруулах 3 ширхэг ухаалаг суултуур суурилуулсан.

Ухаалаг суултуур суурилуулахдаа ашиглалтын үеийн аюулгүй байдал, хэрэглэгчийн гарын авлага болон ашиглах заавар, зөвлөмжийг танилцуулсан.

2.2.2.3. Уурхайн үйл ажиллагаанаас үүсч буй хаягдал уснаас улиралд 2-оос доошгүй удаа дээжлэлт хийж, усны хяналт шинжилгээг тогтмол хийж гүйцэтгэдэг. Ахуйн бохир ус цэвэршүүлэх байгууламжийн гаралт хэсгийн шинжилгээний үр дүнг “Хүрээлэн буй орчин. Усны чанар. Хаягдал ус, Ерөнхий шаардлага MNS4943:2015” стандарттай харьцуулан, цэвэрлэгээний хувь болон дүгнэлтийг боловсруулдаг.

Ахуйн бохир ус цэвэрлэх байгууламжийн оролт, гаралт хэсгийн шинжилгээний үр дүнг хүснэгт 10, 11-т харуулав.

2.2.2.4. Ахуйн бохир ус цэвэршүүлэх байгууламжаас цэвэршүүлсэн бохир усыг баяжуулах үйлдвэрт нийлүүлдэг. Тайлант хугацаанд Стандарт хэмжил зүйн газраар баталгаажуулсан тоолуурын заалтаар 24945 шоо/метр усыг нийлүүлсэн байна. Ахуйн бохир цэвэрлэх байгууламжаас эргүүлэн ашигласан усны хэмжээг сар бүрээр хүснэгт 12-т харуулав.

2.3. ХӨРСӨН БҮРХЭВЧИНД ҮЗҮҮЛЭХ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ ЧИГЛЭЛЭЭР

2.3.1. Сайжруулсан шороон замаас үүсэх тоос хөрсөн бүрхэвчийг бохирдуулахаас сэргийлж уурхайгаас аймаг явах зам дагуу 500 ширхэг улиас мод суулгасан.

2.3.2. Хаягдал тослох материал нь талбайд асгаралт үүсгэн хөрсөн бүрхэвчийг бохирдуулахаас сэргийлж асгаралтын үед хэрэглэх иж бүрдлийг дүүргэлтийн цех, хатаах цех, хөвүүлэх цех, ахуйн бохир цэвэрлэх байгууламжид нийт 4 ширхэгийг байрлуулсан. Асгаралтын иж бүрдлийг ашиглах заавар зөвлөмжийг танилцуулж, самбар байрлуулсан.

2.3.3 Дорнод аймаг, Баянтүмэн өртөөнөөс “Шинь Шинь” ХХК-ийн Улааны орд хүртэлх 127.2 км хайрган авто замын арчлалт засвар үйлчилгээ үзүүлэхээр “Дорнод авто зам” ХХК-тай гэрээ байгуулсан. Хайрган хучилттай авто замын засвар арчлалтанд цас хуримтлагдах хэсгүүдэд шороон далан хийх, цөмөрсөн, суларсан хэсгийг дүүргэх тэгшлэх, зам дагуух байгууламжийг засварлах, цэвэрлэх ажлыг тогтмол хугацаанд хийж гүйцэтгэдэг. Гүйцэтгэгч компаниас сар бүр ажлын тайланг хүлээн авдаг.

2.4. УРГАМЛАН НӨМРӨГИЙГ ХАМГААЛАХ ЧИГЛЭЛЭЭР

2.4.1. Уурхайн тосгоны өнгө үзэмжийг сайжруулах зорилгоор тохижуулалтын ажилд олон наст ургамал /саман ерхөг, соргүй согоовор/, нэг наст ургамал /хумсан цэцэг/ 4345 м² талбайд тарилт хийсэн.

Хүснэгт 13. Ногоон байгууламжинд тариалалт хийсэн талбайн дэлгэрэнгүй

№	Байршил	Нэр, төрөл	Талбайн хэмжээ м ²
1	Оффис баруун тал	Нэгт наст ургамал /хумсан цэцэг/	190
2	Буудлын зүүн болон баруун тал	Олон наст ургамал, нэгт наст ургамал /хумсан цэцэг/	1208
3	Бараа материалын агуулахын эргэн тойронд	Олон наст ургамал, нэгт наст ургамал /хумсан цэцэг/	109
5	Эмнэлэг болон жижиг оффис	Олон наст ургамал, нэгт наст ургамал	402
6	Гал тогоо	Олон наст ургамал, нэгт наст ургамал /хумсан цэцэг/	560
7	Хаягдал дугуйгаар хийсэн цэцгийн мандал	Нэг наст ургамал /хумсан цэцэг/	553
8	Лабораторийн баруун тал	Олон наст ургамал, нэгт наст ургамал /хумсан цэцэг/	817

9	Баяжуулах үйлдвэр	Нэг наст ургамал /хумсан цэцэг/	203
Тохижилтын ажлын талбай хэмжээ			4042
Явган хүний замын хажуугаар хийгдсэн тариалалт			
1	Цэцгийн мандал	Хумсан цэцэг	303
Талбайн хэмжээ			
Нийт талбайн хэмжээ			4345

2.4.2. Суурьшлын бүс болох 1-р өргөх насосны станцад 100 ширхэг үхрийн нүд, гүний усан санд 100 ширхэг нохойн хошуу суулгасан. Энэ онд хаягдлын сангийн далан өндөрлөх төлөвлөгөөт ажил хийгдсэн тул ногоон байгууламж, тохижуулалтын ажил хийгдээгүй болно.

2.5. ФИЗИК НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ ЧИГЛЭЛЭЭР

2.5.1. Дуу шуугиантай ажлын байруудад дуу шуугиан хэмжих dBadge2 kit with 1 Dosimeters багажаар сард 2 удаа, тайлант хугацаанд 17 удаагийн хэмжилт хийсэн.

2.5.2. Нэг бүрийн хамгаалах хэрэгслийн олголтыг “Ажлын хувцас, нэг бүрийн хамгаалах хэрэгсэл олголт, ашиглалтын журам”-н дагуу тогтмол олгодог. Хөдөлмөрийн нөхцлийн үнэлгээгээр ажлын байрны дуу шуугиан зөвшөөрөгдөх хэмжээ /85дб/-ээс өндөр ажлын байранд ажиллагсдад сонсголын эрхтэн хамгаалах чихэвч болон чихний бөглөөг 2067 ширхэгийг олгосон байна.

2.6. ХҮНИЙ ЭРҮҮЛ МЭНД

2.6.1. Мэргэжлээс шалтгаалах өвчлөлийн эрүүл мэндийн хугацаат үзлэгийг 2024 оны 10-р сарын 03-ны өдрөөс 07-ны өдрийг дуустал Хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн үндэсний төвтэй гэрээ байгуулан уурхайн бүсэд зохион байгуулсан. Үзлэгт 320 ажилтан хамрагдсан.

2.6.2. 2016 оны 11 дүгээр сарын 06-ны өдрийн 941 тоот захирлын тушаалаар батлагдсан “Хор саармагжуулах бүтээгдэхүүн олгох тухай” тушаалын дагуу 10 нэр төрлийн бүтээгдэхүүнийг улирлын онцлогоос хамааран олгож байна. Уурхайн бүсэд ажиллаж буй нийт ажилтанд сүү, тараг, аньс, чацарганы шүүс зэрэг дархлаажуулах бүтээгдэхүүнийг тогтмол олгож байна.

3. НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ


Улааны холимог металлын ордыг далд уурхайн аргаар ашиглах төслийн үргэлжлэх хугацаа 33 жил бөгөөд 2020 онд хийгдсэн байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний шинэчилсэн тодотголын тайлангийн хүчинтэй хугацаанд уурхайн хаалтын ажил хийгдэхгүй болно.

Хүснэгт 14. 2024 онд хийгдсэн нөхөн сэргээлтийн мэдээ

№	Нөхөн сэргээлт хийсэн талбайн байршил	Техникийн нөхөн сэргээлт (м ²)	Биологийн нөхөн сэргээлт (м ²)
---	---------------------------------------	--	--

1	2023 онд Мардай тосгонд техникийн нөхөн сэргээлт хийсэн талбай		6 га
2	Мардай тосгон	1.5 га	
Нөхөн сэргээлт хийсэн нийт хэмжээ		1.5 га	6.0 га

3.1. 2023 онд хуучин Мардай тосгонд техникийн нөхөн сэргээлт хийсэн 6 га талбайд биологийн нөхөн сэргээлт хийсэн. Ургамлын тариалалт хийхдээ үетэн 40% /саман ерхөг, ботууль, өлөнгө, согоовор/, буурцагтан 60% /царгас, хүцэнгэ, хошоон/ байхаар үрийн холимгийг тариалсан. Тариалалтын дараах усалгаа, арчилгааны ажлыг тогтмол хийж гүйцэтгэсэн.



Зураг 30. Тариалалтын ажлын явц



Зураг 31. Усалгааны ажлын явц



Зураг 32. Тариалалтын дараах байдал

4. БИОЛОГИЙН ОЛОН ЯНЗ БАЙДЛЫГ ДҮЙЦҮҮЛЭН ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭ

4.1. Орон нутгийн тусгай хамгаалалтанд авсан газарт идэвхтэн байгаль хамгаалагчаар Дашбалбар сумын Сэвсүүл Жараахай багийн иргэн Н.Наранмандахтай 2019 оны 11-р сарын 14-ний өдрөөс эхлэн хөдөлмөрийн гэрээ байгуулан одоог хүртэл хамтран ажиллаж байна. Идэвхтэн байгаль хамгаалагч нь дүйцүүлэн хамгаалах талбай дахь булгуудын хашаа хаалтны бүрэн бүтэн байдал, тарвага нутагшуулсан газарт хяналт тавьж, сар бүр ажлын тайлан илгээдэг.

4.2. Ой хээрийн түймэр болон бусад байгалийн гамшиг тохиолдохоос урьдчилан сэргийлэх, гамшгийн үед яаралтай мэдээлэх утасны дугаартай мэдээллийн 20 ширхэг самбаруудыг байршуулсан. Байгалийн гамшиг тохиолдсон үед авах арга хэмжээний талаар нутгийн иргэдэд тараах материал, мэдээллийг 13 малчин өрхийн 43 иргэнд хүргэсэн.

4.3. Дүйцүүлэн хамгаалах газар дахь Галдан, Зүүн сүүж, Баруун сүүж, Жаал, Зүүн Жараахайн булгуудын эхийг цэвэрлэх ажлыг 9-р сард зохион байгуулсан. Цэвэрлэгээнд 4 хүн оролцож, ундааны сав, шил, гялгар уут, хашааны хаягдал төмөр зэрэг 200 кг орчим хог цэвэрлэсэн.

4.4, 4.11. Сэвсүүл Жараахай багийн нутаг дахь Жаалын булгийн эхийг 2023 онд хашиж хамгаалсан. Тайлант онд биологийн аргаар тохижуулах ажлын хүрээнд Жаалын булгийн эхэнд хөрсний ус барих, татах зорилгоор 1100 бургасыг суулгасан.

4.5. Идэвхтэн байгаль хамгаалагч нь Улиастайн шил, Өрөлийн мод зэрэг газруудад ургаж буй мод, орчин тойрны хэсгүүдийн нөхцөл байдалтай танилцаж ажилладаг бөгөөд эдгээр газруудаар нүүдэллэн өнгөрч байгаа амьтны аймгийн төрөл зүйлийн талаар бүртгэл хөтөлдөг. Бүртгэлээ тайландаа тусгаж, сар бүр илгээдэг.

4.6. Орон нутгийн тусгай хамгаалалтай газрын Улиастайн шил орчимд ой, хээрийн түймрээс хамгаалах арга хэмжээний хүрээнд 1 га талбайд түймрийн шороон зурвас татсан.

4.7. Дүйцүүлэн хамгаалах зардлыг Дашбалбар сум хариуцаагүй тул хөдөлмөрийн аюулгүй байдал, цацрагийн хамгаалал, байгаль орчныг хамгаалах талаар хийгдсэн ажлын тайланг хагас жилийн байдлаар Дашбалбар сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын ажлын албанд хүргүүлсэн.

4.8. 2021, 2023 онуудад Дааврын булагт нутагшуулсан 100 толгой тарваганд 2024 онд тооллого, мониторингийн ажлыг “Дорнын талын өргөө” ХХК-тай хамтран ажиллах гэрээ байгуулан хийж гүйцэтгүүлсэн. Дааврын булагт нутагшуулсан тарваганаас 131 толгой бойжиж байгаа ба үүнээс 12 толгой тарвага анх нутагшуулсан газраас баруун зүгт 3 км газарт, 8 толгой нь зүүн зүгт 0.5 км газарт шилжин нүүдэллэсэн байна. Энэ онд шинээр 34 мөндөл гарсан ба цаашдаа өсөх хандлагатай байна.

4.9. Мардайн тосгонд 10 га талбайд техникийн нөхөн сэргээлт хийхээр төлөвлөгдсөн. 8.5 га талбай нь ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй “Адамас Майнинг” ХХК-ийн талбайтай давхцал үүссэн байна. Иймд давхцал үүсээгүй 1.5 га талбайд 2024 оны 09-р сарын 12-ноос 09-р сарын 15-ны өдрүүдэд техникийн нөхөн сэргээлтийг хийж гүйцэтгэсэн.

4.10. "Дорнын талын өргөө" ХХК-тай гэрээ байгуулан 2024 оны 07-р сарын 10-ны өдөр Дашбалбар сумын Сэвсүүл Жараахай багийн нутагт 23 бурхи, 19 нагаа, 8 мөндөл буюу нийт 50 толгой Монгол тарвага нутагшуулсан. Тарвага нутагшуулахад Дашбалбар сумын байгаль хамгаалагч, идэвхтэн байгаль хамгаалагч нар байлцан нутагшуулах газар, дошыг зааж өгөн хамтран ажилласан.

5. НҮҮЛГЭН ШИЛЖҮҮЛЭХ, НӨХӨН ОЛГОВОР ОЛГОХ АРГА ХЭМЖЭЭ

Төслийн үйл ажиллагаатай холбоотой айл нүүлгэн шилжүүлэх ажиллагаа хийгдэхгүй болно.

6. ТҮҮХ, СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭ

Төслийн үйл ажиллагаатай холбоотой түүх соёлын өвийг хамгаалах ажил хийгдэхгүй болно.

7. ОСОЛ, ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

7.1. ХИМИЙН БОДИСЫН ТӨРӨЛ ХЭМЖЭЭ, ХЭРЭГЛЭЭ

Химийн бодисын агуулах нь баяжуулах үйлдвэрээс зүүн хойд зүгт 300 гаруй метрт байршилтай, 864.4м² талбайтай, 5.5м өндөртэй, төмөр бетон раман цутгамал бүхий нэг давхар тоосгон барилга байдаг. Тус агуулах нь хойд, урд гэсэн хоёр орох хаалгатай мөн хойд, урд гэсэн аврах гарцтай. Нийт найман ширхэг цахилгаан агааржуулалтын системтэй.

Химийн бодис тус бүр дээр хор аюулын лавлах самбарыг байршуулж, ажилтны ажлын байрны аюулгүй ажиллагааны зааварчилгаа, үүрэг, хариуцлага зэргийг дагаж мөрдөн ажилладаг.

Баяжуулах үйл ажиллагаанд ашиглагдах урвалж бодисын хэрэглээний тооцоог хүснэгт 15-д үзүүлэв.

Хүснэгт 15. Химийн бодисын хэрэглээ

№	Нэршил	Химийн томъёо	Зориулалт	Зарцуулалт гр/тн	Жилд зарцуулах бодисын хэмжээ, кг
1	Натрийн сульфит	Na ₂ SO ₃	Дарагч	600	200'000
2	Цайрын сульфат	ZnSO ₄	Идэвхижүүлэгч	800	950'000
3	Аэрофин 3418А	C ₄ H ₉ OCSSNa	Цуглуулагч	80	100'000

4	Аэрофлот 25	$(C_7H_7O)_2PSSH$	Цуглуулагч	60	100'000
6	Зэсийн сульфат	$CuSO_4$	Идэвхижүүлэгч	200	400'000
7	Азотын хүчил	HNO_3			80'000
8	Давсны хүчил	HCl			50'000
10	Этил тиокарбамат	SN-9	Цуглуулагч	200	15'000

7.2. ТОХИОЛДОЖ БОЛЗОШГҮЙ ЭРСДЭЛ

“Шинь Шинь” ХХК-ийн Улааны уурхайн гамшиг эрсдэлийн нарийвчилсан үнэлгээг мэргэжлийн байгууллага болох “Дат Консалтинг” ХХК-иар 2022 онд гүйцэтгүүлсэн. 2024 онд гамшгаас хамгаалах төлөвлөгөөнд нэмэлт тодотгол хийлгүүлж Онцгой байдлын газраар батлуулан хэрэгжүүлж ажиллаж байна.

7.3. ОСОЛ, ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

7.3.1. БАЙГАЛИЙН ГАМШГААС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ ЧИГЛЭЛЭЭР

7.3.1.1. Дорнод аймгийн болон Дашбалбар сумын цаг агаарын мэдээг 5 хоногоор нь гаргаж өдөр тутмын ажилд ашиглаж байгаа бөгөөд тайлант хугацаанд цасан шуурга, аадар бороо, хүчтэй салхитай болон манантай үед гадаах ажлыг нийт 7 удаа зогсоосон байна.



Зураг 33. Манан болон шороон шуургатай үеийн нөхцөл байдал

7.3.1.2. Дорнод аймгийн Онцгой байдлын газартай хамтран “Ой хээрийн түймэр, объектын гал түймэр, галын аюулгүй байдал” сэдэвт сургалтыг 2024 оны 05-р сарын 28, 29-ний өдрүүдэд танхим болон практик хосолсон хэлбэрээр зохион байгуулсан.

Мөн “Гамшиг, аюулт үзэгдэл, анхны тусламж” сэдэвт сургалтыг 2024 оны 10-р сарын 20, 21-ний өдрүүдэд уурхайн бүсэд тус тус зохион байгуулсан. Сургалтад давхардсан тоогоор 331 ажилтан хамрагдсан.



Зураг 34. Танхимын сургалт





Зураг 35. Практик сургалт

7.3.1.3. Гал түймэртэй тэмцэх багаж хэрэгсэл, галын гидрант, галын хор зэргийг тогтсон стандартын дагуу уурхайн тосгоны хэмжээнд бүх объектуудад байрлуулж бэлэн байдлыг хангаж ажилладаг. Уурхайн бүсэд 20 ширхэг галын сараалж, 20 ширхэг галын гидрант, 512 ширхэг галын хор байрлуулсан байдаг. Тайлант хугацаанд 20 удаагийн хяналтыг хийж, хугацаа нь дууссан галын хор зэргийг тухай бүр нь сольж шинэчилсэн.



Зураг 36. Галын хор болон гал унтраах багаж хэрэгслийг шалгаж байна

7.3.1.4. Уурхайн бүсэд гамшиг ослыг мэдээллэх 5 ширхэг дуут дохиололыг суурилуулан, бэлэн байдлыг ханган ажиллаж байна. “Шинь Шинь” ХХК-ийн “Гамшиг ослын үед дуут дохиогоор ажиллах журам”-ын дагуу сар бүрийн 05, 20-ний өдрүүдэд хэвийн ажиллагааг шалгадаг ба бүх дуут дохиолол эвдрэл, гэмтэлгүй хэвийн ажиллагаатай байна.



Зураг 37. Дуут дохиолол шалгаж байна

7.3.2. ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ОСЛООС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ ЧИГЛЭЛЭЭР

7.3.2.1. Жилийн ажлын төлөвлөгөөний дагуу баяжуулах үйлдвэрийн цехүүд, авто тээврийн хэлтэс, чанар хяналтын хэлтэс болон туслан гүйцэтгэгч нэгжүүдийн үйл ажиллагаанд аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн хяналтыг өдөр тутам болон сар бүр 600 удаа хийж гүйцэтгэсэн.

Хөдөлмөр хамгааллын хувцас, нэг бүрийн хамгаалах хэрэгслийг бүрэн, зөв хэрэглэсэн эсэх, ажилд гарахын өмнө ажлын өдөр тутмын аюулгүй ажиллагааны зааварчилгаа авсан эсэх, ажлын байрны анхан шатны хяналтыг хөтөлсөн зэрэг үйл ажиллагаанд хяналт тавьж ажилладаг.

Тайлант хугацаанд ХАБЭА-н хяналтын явцад аюулыг мэдээлэх хуудсаар аюулыг мэдээлж, арилгах арга хэмжээ аван ажиллаж байна.





Зураг 38. Үйлдвэрийн хэлтэс цехүүдээр хяналт шалгалт хийж байна

7.3.2.2. Монгол Улсын Хөдөлмөр, Нийгмийн Хамгааллын Сайдын Тушаал А/370 тушаал, MNS 4969:2000 стандартыг хангаж хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн сургалт, аюулгүй ажиллагааны зааварчилгаануудыг цаг тухай бүрт тогтмол хийж байна. Тайлант хугацаанд сургалтад хамрагдсан тоон үзүүлэлтийг нэгтгэн, хүснэгтээр үзүүлэв. /2023.12.25-2024.10.25/

Хүснэгт 16. Сургалтын тоон мэдээлэл

№	Хэлтэс, цех	Эрсдэглэй аюулын байрны сургалтын тоо	Үндэглэсэн занварчилгаа	Өөр аюулын байранд шилжсэн ажилтны сургалт	Дамган занварчилгааны сургалт	Зочдын занварчилгаа	Тусламж гүйцэтгэгч компанийн	Нийт ажилчдын сургалт	Нийт
1	Баяжуулах үйлдвэр оффис		6			78		4	88
2	Аюулгүй цех	25	3	1	12			233	274
3	Хатаах цех	11	2	3	14			226	250
4	Булгах цех		2	2				222	226
5	Дуургалт цех	15	1					139	156
6	Зэвжүүлэх цех		4		12			113	129
7	Гайрригч		3		2			108	113
8	МХТ-ын хэлтэс		5	1		6		66	78
9	Аж ахуйн хэлтэс		1					41	42
10	Автын хэлтэс		27		17			100	212
11	ХАБ ЗАБОХ		1	1	10	38		65	117
12	Хувийн Нөөц		1					13	14
13	Лавар, утасгийн	7	10		10			45	81
14	ВОЭТ		2		2	4		25	33
15	ТМӨМ						6		6
16	Бөн-цэг						12	10	22
17	Цэцгийн Сэр						20	10	30
18	Бусад бусад						15	8	33
19	ХУЕМ						0	15	34
20	Бусад		1			165	1	15	183
	Нийт	59	89	10	79	202	63	1526	2169



Зураг 39. Сургалтын үеэр

7.3.2.3. Нийт ажилтны сургалтыг 7 хоног бүрийн лхагва гарагт ХАБЭАБОХэлтсийн ХХ-ын инженер, байгаль орчны инженер, хөдөлмөрийн эрүүл ахуйн инженер, эмч нар Хөдөлмөр нийгмийн хамгааллын яамны сайдын А/173 тоот тушаалын сэдвийн хүрээнд ХАБЭА болон байгаль орчин, эрүүл мэндийн сургалтыг батлагдсан төлөвлөгөө, хуваарийн дагуу уурхайн бүсэд зохион байгуулсан.

Тайланд хугацаанд сургалтад давхардсан тоогоор 1343 ажилтан хамрагдаж чанар 89.3 хувь, хамрагдалт 92 хувьтайгаар зохион байгуулагдсан.



Зураг 40. Дотооддоо зохион байгуулсан нийт ажилтны сургалт

2024 оны нийт ажилтны сургалтыг мэргэжлийн байгууллага буюу Дорнод аймгийн Политехник коллежийн мэргэжлийн багш нар 2024 оны 04-р сарын 23, 30, 05-р сарын 07-нд гэсэн 3 ээлжээр дараах сэдвийн хүрээнд зохион байгуулсан.

- ХАБЭА-н тухай хууль
- Ажлын байран дахь эрүүл мэндэд сөргөөр нөлөөлдөг хүчин зүйлс, түүний төрлүүд, мэргэжлээс шалтгаалал өвчлөлүүд
- Хувцас, хамгаалах хэрэгсэл
- Аюул осолд өртсөн хүнд үзүүлэх анхан шатны тусламж
- Эрсдлийг илрүүлэх арилгах
- Үйлдвэрийн осолд хүргэдэг аюултай хүчин зүйлс, урьдчилан сэргийлэлт



Зураг 41. Мэргэжлийн байгууллагын сургалт

7.3.2.4. “Шинь Шинь” ХХК-ийн Гүйцэтгэх захирлын 2021 оны 10 дугаар сарын 10-ны өдрийн 473 тоот тушаалаар батлагдсан “Ажлын хувцас, нэг бүрийн хамгаалах хэрэгсэл олголт, ашиглалтын журам”-н дагуу дараах байдлаар олгоод байна.

Хүснэгт 17. Гар хамгаалах хэрэгсэл олголт

№	Нэр төрөл	Тоо /ш/
1.	Өвлийн бээлий	1939
2.	Ханцуйвч	122
3.	Резинэн бээлий / үйлдвэр/	1147
4.	Ажлын бээлий /арьсан/	323
5.	Гагнуурын бээлий	361
6.	Ажлын бээлий /резинэн алгатай/	14819
7.	Ажлын цагаан бээлий	2287

Хүснэгт 18. Нүүр, нүд, толгой хамгаалах хэрэгсэл олголт

№	Нэр төрөл	Тоо /ш/
1.	Шилбэний хамгаалалт	0
2.	Нүдний шил	950
3.	Чихний бөглөө	2067
4.	3м маск /2шүүлтүүртэй/	86
5.	3м маск /1шүүлтүүртэй/	1832
6.	Нэг удаагын маск 2.5 рм	14621
7.	3м шүүгч цаас	11764
8.	Каск	113
9.	Өвлийн каск	0

Хүснэгт 19. Ажлын тусгай хувцас олголт

№	Нэр төрөл	Тоо /ш/
1.	Эсгий оймс	7
2.	Усны гутал	268
3.	Далд уурхайн хувцас	0
4.	Шохойн комбинзон	221
5.	Өвлийн ажлын гутал	53
6.	Ажлын гутал	245
7.	Өвлийн ажлын хувцас	121
8.	Ажлын хувцас	448

7.4. ХИМИЙН БОДИСЫН ЭРСДЭЛИЙГ БУУРУУЛАХ ЧИГЛЭЛЭЭР АВЧ ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭ

7.4.1. Химийн бодисын агуулах, шохойн агуулах болон химийн бодис ашигладаг хэлтэс цехүүдэд химийн бодис тус бүрийн ХАЛ-ыг тухай бүр нь шинэчлэн байрлуулж ажилладаг. Мөн химийн бодисын ХАЛ-ыг гарын авлага байдлаар бэлтгэж химийн бодистой харьцаж ажилладаг ажилтнуудад тарааж, мэдээлэл хүргэсэн.



Зураг 42. ХАЛ болон тараах материал

7.4.2, 7.4.3, 7.4.4. Химийн бодистой харьцаж ажилладаг ажилтан бүр химийн бодистой аюулгүй харьцах мэдлэг, дадал, чававхыг нэмэгдүүлэх сургалтыг тогтмол зохион байгуулдаг. Баяжуулах үйлдвэрийн химийн бодис ашигладаг хэлтэс цехүүдийн ажилтнууд болон туслан гүйцэтгэгч “Цагаан сор” ХХК-ийн химийн бодис ачигч нарт химийн бодистой харьцах аюулгүй ажиллагаа, асгаралтын иж бүрдэл хэрэглэх, химийн хорт болон аюултай бодисын тухай хууль тогтоомж, аюул ослын үед авах арга хэмжээ болон аюултай хог хаягдлын талаарх сэдвүүдийн хүрээнд химийн инженерүүд 7 удаагийн сургалтыг зохион байгуулсан. Сургалтын дараа мэдлэг шалгах сорил авч, давтан сургалтад хамруулсан. Сургалтад давхардсан тоогоор 88 ажилтан хамрагдсан.



Зураг 43. Сургалтын үеэр

7.4.5. Химийн бодисын агуулах болон химийн бодис хэрэглэдэг хэлтэс цехүүдэд химийн бодисын хадгалалт, хэрэглээнд өдөр тутмын ХАБЭА-н хяналтыг тухай бүр тавьдаг. 2024 оны дотоод хяналт, шалгалтын төлөвлөгөөр 08-р сард төлөвлөгөөт хяналт шалгалтыг зохион байгуулсан. Хяналтаар илэрсэн сайжруулах ажлыг албан бичгээр хүргүүлэн, дутагдлыг арилган ажилласан.

7.4.6. Химийн бодисын ашиглалт, зарцуулалтын бүртгэлийг бодис нэг бүрээр гаргаж, агуулахын үлдэгдэл нөөц, ашиглалтын зарцуулалтыг дараах байдлаар гаргасан.

Хүснэгт 20. Химийн бодисын ашиглалт

№	Бодисын нэр, томьёо	Уялдуусан системийн код	Хаана хадгалдаг	Эхний үлдэгдэл, кг 2024 оны 01 сарын 01	Хүлээн авсан нийт хэмжээ, кг	Нийт хэрэглэсэн хэмжээ, кг	2024 оны 10 сарын 25 үлдэгдэл, кг
	2	3	4	5	6	7	8
1	Цайрын сульфат $ZnSO_4$	7446-20-0	Химийн бодисын тусгай агуулах	286,000	243,810	452,810	77,000
2	Зэсийн сульфат $CuSO_4$	7758-98-7		11,500	140,750	152,250	0
3	Натрийн бутилксантат $C_4H_9OCSSNa$	141-33-3		15,650	64,450	66,350	13,750
4	Кониферолын тос $C_{10}H_{17}OH$	9/3/8002		15,400	0	7,000	8,400
5	Дикрезил-дитиофосфорын хүчил $(C_7H_7O)_2PSSH$	27157-94-4		91,800	0	16,600	75,200
6	Кальцийн оксид CaO	1305-78-8	Шохойн агуулах	465,840	3,787,580	3,780,793	472,627
7	Натрийн диэтилдитиокарбамат $(C_2H_5)_2NCSSNa \cdot 3H_2O$	20624-25-3	Химийн бодисын тусгай агуулах	43,250	0	0	43,250
8	Натрийн этилксантат $C_2H_5OCSSNa$	140-90-9		0	0	0	0
9	Натрийн сульфит Na_2SO_3	7757-83-7		0	30,000	26,000	4,000
10	Давсны хүчил HCl	7647-01-0		4,600	5,014	5,290	4,324
11	Азотын хүчил HNO_3	7697-37-2		3,078	15,012	13,770	4,320

Химийн бодисын агуулахад химийн бодис ирэх тохиолдолд Дашбалбар сумын байгаль хамгаалагч болон ХАБЭА-н ажилтан, хэлтэс цехүүд химийн бодис авах үед ХАБЭА-н ажилтан хяналт тавьж ажилладаг.





Зураг 44. Химийн бодис буулгаж буй үед хяналт тавьж байна

7.4.7. Байгаль орчны судалгаа, шинжилгээний төвийн “Химийн бодисын эрсдлийн үнэлгээ” сэдэвт чадавхжуулах сургалтад химийн инженер амжилттай хамрагдаж, гэрчилгээ гардан авсан.



Зураг 45. Сургалтын гэрчилгээ

8. ХОГ ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

8.1. Хог хаягдлыг цуглуулах, ангилан ялгах, тээвэрлэх үйл ажиллагааг орон нутгийн “Дашбалбар хөгжил” ОНӨААТҮГазартай “Хог хаягдал цуглуулах, тээвэрлэх үйлчилгээ үзүүлэх” ажил гүйцэтгүүлэхээр гэрээ байгуулан хамтран ажиллаж байна. “Дашбалбар хөгжил” ОНӨААТҮГазрын сар бүр ирүүлсэн ажлын тайлантай танилцах мөн гэрээний дагуу ажил гүйцэтгэх явцад хяналт тавьж ажилладаг.

8.2. ХАБЭА-н нийт ажилтны 02-р сарын сургалтад 2021 оны 02-р сарын 07-ны өдрийн захирлын дугаар 55 тушаалын хавсралт Хог хаягдлыг ангилан ялгах, тээвэрлэх, түр хадгалах, устгах журам танилцуулах мөн ахуйн, үйлдвэрийн, аюултай хог хаягдлын ангилан ялгалтын талаарх сургалтыг зохион байгуулсан. Сургалтад нийт 289 ажилтан хамрагдсан.



Зураг 46. Сургалт мэдээлэл хүргэж буй нь

8.3. Хог хаягдлын тухай хууль тогтоомжийг өдөр тутмын үйл ажиллагаандаа мөрдлөг болгон ажиллаж байна. Хог хаягдлын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.5 дахь, 20 дугаар зүйлийн 20.3 дахь заалтуудын дагуу мал амьтан орохоос сэргийлэн хашаажуулалт, хаягжуулалт, камержуулалтын ажлыг хийж гүйцэтгэсэн.



Зураг 47. Хог хаягдлын цэгийн камержуулалт

8.1. АХУЙН ХОГ ХАЯГДЛЫН АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

8.1.1. Хэлтэс цехүүд, амралтын байрууд, оффисын байрууд нь тус бүртээ ангилан ялгалтын хогийн савтай. Дахин боловсруулах боломжтой хуванцар савыг түр хадгалах цэгт цуглуулан “Дашбалбар хөгжил” ОНӨААТҮГазарт шилжүүлдэг. Тайлант хугацаанд 410 кг хуванцар савыг шилжүүлсэн байна.

8.1.2. 2024 онд үйл ажиллагаагаа явуулж эхэлсэн бетон зуурмагийн цех, шалган 2-ын урд хог хаягдлыг ачиж, тээвэрлэхэд зориулсан хаалга түгжээтэй, галд тэсвэртэй материалаар хийгдсэн ангилан ялгалтын хогийн савыг байрлуулсан. Ангилан ялгалтын тэмдэг, тэмдэглэгээг байршуулж, өнгөөр ялган будаж тохижуулсан.



Зураг 48. Ангилан ялгалтын хогийн сав

8.1.3. Хог хаягдлыг цуглуулах, ангилан ялгах, тээвэрлэх үйл ажиллагааг орон нутгийн “Дашбалбар хөгжил” ОНӨААТҮГ газартай “Хог хаягдал цуглуулах, тээвэрлэх үйлчилгээ үзүүлэх” ажил гүйцэтгүүлэхээр гэрээ байгуулан хамтран ажиллаж байна. “Дашбалбар хөгжил” ОНӨААТҮГ газар гүйцэтгэсэн ажлынхаа тайланг тухай бүр ирүүлдэг.

8.1.4. Уурхайн бүсэд үүссэн хог хаягдлыг цэвэрлэх, байгаль орчин болон хүний эрүүл мэндэд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах урьдчилан сэргийлэх зорилгоор 2024 оны 02, 03, 04, 05, 07, 08 болон 09-р саруудад бүх нийтийн цэвэрлэгээг зохион байгуулсан. Уг цэвэрлэгээнд “Шинь Шинь” ХХК-ийн бүх хэлтэс, цехүүд болон туслан гүйцэтгэгч компаниудаас нийт 346 хүн хамрагдаж, 13.8 тн хог хаягдал цэвэрлэсэн.





Зураг 49. Бүх нийтийн цэвэрлэгээний үеэр

8.2. ҮЙЛДВЭРИЙН ХОГ ХАЯГДЛЫН АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

8.2.1. Уурхайн өдөр тутмын үйл ажиллагаанаас үүссэн төмрийн хог хаягдлыг хэлтэс, цехүүд түр хадгалах талбайд хадгалж, төмрийн хог хаягдлын цэгт шилжүүлэн хадгалж байна.

8.2.2. Уурхайн дулааны эх үүсвэр уурын зуухны төлөвлөгөөт их засварын ажил тайлант онд хийгдсэн. Засварын ажлаас үүссэн 130 тн хог хаягдлыг үйлдвэрийн хог хаягдлын цэгт бүртгэн шилжүүлсэн. Мөн 7000 гаруй ширхэг тоосгыг уурхайн тосгоны тохижуулалтын ажилд дахин ашигласан.



Зураг 50. Дахин ашиглах барилгын хог хаягдал

8.3. АЮУЛТАЙ ХОГ ХАЯГДЛЫН АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

8.3.1. Уурхайн бүсэд эрүүл мэндийн анхны тусламж үйлчилгээг үзүүлэх, зорилгоор Дорнод аймгийн БОЭТ-тэй хамтран ажиллах гэрээ байгуулан ажилладаг. Эмнэлгийн гаралтай хог хаягдлыг уурхайн бүсэд томилолтоор ирж ажиллаж буй эмч, сувилагч нар хариуцан, Дорнод аймгийн БОЭТ-д хүргүүлж, устгуулдаг. Эхний хагас жилийн байдлаар нийт 17 удаа, 81.2 кг хог хаягдлыг устгуулсан байна.

8.3.2. Төслийн үйл ажиллагаанаас үүсч буй аюултай хог хаягдлыг тусгай зөвшөөрөлтэй, гэрээт байгууллагад шилжүүлэх хүртэл ангилал тус бүрээр бүртгэл хөтлөн, түр хадгалах цэгт хадгалдаг. Тайлант хугацаанд тусгай зөвшөөрөлтэй

гэрээт байгууллагад 19660 литр ашигласан тос масло, 15500 кг химийн бодисын шуудайг тушаасан байна.

Химийн бодисын шуудай 3626 кг, хуванцар сав 358.5 кг, 600 литр ашигласан тос масло зэрэг аюултай хог хаягдлыг ангилал тус бүрээр нь бүртгэл хөтлөн, түр хадгалах цэгт хадгалж байна.

9. ОРЧНЫ ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨР

Төслийн үйл ажиллагааны үр дүнд агаар, хөрсөн бүрхэвч, усан орчин, ургамлан нөмрөгт хими, физикийн шинж чанар, хүнд металлын агууламжид гарч болох өөрчлөлт мөн тэдгээр үзүүлэлт нь холбогдох стандартын шаардлагыг хангаж буй эсэхийг хянах, хавар, намрын төлөвлөгөөт дээжлэлтийг авч хөндлөнгийн байгууллагатай хамтарч хяналт-шинжилгээний хөтөлбөрийг хэрэгжүүлэн ажиллаж байна.

9.1. АГААРЫН БОХИРДЛЫГ ХЯНАХ

Дорнод аймгийн Ус цаг уур орчны шинжилгээний төвтэй гэрээний дагуу хамтран ажиллаж, гадаад болон дотоод орчинд агаарын сорьцыг 15 цэгт агаарын даралт гПа, агаарын температур, нийт тоос, тоосонцор, азотын давхар исэл, хүхэрлэг хий, угаарын хий гэх мэт элементүүдийг шинжлүүлдэг.

Хүснэгт 21. 2024 оны Агаарын найрлагын шинжилгээний дүн

№	Агаарын сорьц авсан цэгийн байршил	Агаарын даралт		Агаарын температур		Хүхэрлэг хий		Нийт тоосонцор		Азотын давхар исэл	
		гПа		с		мкг/м3		мкг/м3		мкг/м3	
		6р сар	9-р сар	6р сар	9-р сар	6р сар	9-р сар	6р сар	9-р сар	6р сар	9-р сар
1	Хүдрийн овоолго орчим	693.3	696	26.4	20.9	10	5	36	107	31	38
2	Дотоод тээврийн зам	693.4	695.2	25.5	21.2	9	4	43	44	9	21
3	Дүүргэлт цех	693.5	695.6	24	21.3	12	6	166	154	22	27
4	Хөвүүлэх цех	693.8	695.4	22.7	21.3	10	7	143	303	15	30
5	Хатаах цех	693.9	695.1	21.1	21	9	3	22	388	13	10
6	Бутлах цех	694.1	695.8	21.4	21	26	91	2080	4900	13	57
7	Ажилчдын байр орчим	694	695.5	20.5	22.3	9	4	11	5	24	21
8	Лаборатори дотор	692.8	694.7	21.5	17.4	8	4	526	133	37	6
9	Тэсрэх бодисын агуулах орчим	692.9	694.6	22.2	18.9	12	5	18	1	6	2
10	Далд уурхайн ам	692.8	694.5	24.4	19.5	10	4	118	89	9	6
11	Малчин айлын гадаа	692.6	696.2	26.2	18	20	6	10	5	15	4
12	Буцах усан сан	692.7	696.2	26.6	18.4	18	6	14	6	4	12

13	Хаягдлын сан	692.8	696.4	25.9	16.5	12	4	410	4	9	6
14	Хаягдлын сангаас баруун урд	692.8		26.9		6		18		6	
15	Гадаад тээврийн зам эдэлбэрт өртөөгүй талбай	692	696.2	28.6	15.1	1	5	12	9	4	4
Стандарт(MNS 4585:2016)						450		500		200	

Уурхайн тосгоны агаар дахь хүний эрүүл, аюулгүй орчинд амьдрах нөхцлийг бүрдүүлэх, экосистемийн тэнцлийг хангах зорилгоор хүрээлэн байгаа агаар болон байрны доторх орчны агаар дахь түгээмэл тархацтай бохирдуулах бодисын хүлцэх хэмжээг “Агаарын чанар. Техникийн ерөнхий шаардлага MNS 4585:2016” стандарттай харьцуулдаг. Хоёр удаагийн агаарын сорьцын хариугаар дүгнэлт хийхэд бутлах цех, лабораторийн хэлтэст нийт тоосонцор хүлцэх агууламжаас хэтэрсэн бол агаарын сорьц авсан бусад цэгүүд агаарын чанарын стандартад нийцэж, хүлцэх агууламжаас хэтрээгүй байна.

Агаарын бохирдлын дотоод хяналт

Агаарын чанарын хяналт шинжилгээг Drager X-am 5000 загварын зөөврийн багажийг ашиглан гадаад болон дотоод орчинд нийт 20 цэгт тайлант хугацаанд 16 удаагийн хэмжилт хийж гүйцэтгэсэн байна. Тус зөөврийн багажаар агаар дахь метан хий (CH_4), хүхэрлэг хий (SO_2), азотын давхар исэл (NO_2), хүхэрт устөрөгч (H_2S), нүүрс төрөгчийн дутуу исэл (CO) зэрэг хийнүүдийг хэмжиж, “Агаарын чанар. Техникийн ерөнхий шаардлага MNS 4585:2016” стандартын үзүүлэлттэй харьцуулдаг.

9.2. УСНЫ БОХИРДЛЫГ ХЯНАХ

Улааны уурхайн төслийн талбайд ажиллаж, амьдарч байгаа ажилчдыг эрүүл, аюулгүй орчинд ажиллаж амьдрах нөхцөл боломжоор хангах үүднээс усны эх үүсвэрүүдэд эрүүл ахуйн хяналтыг тогтмол тавин ажиллаж байна. Энэхүү хяналтын хүрээнд 2024 онд Улааны уурхай төслийн усан сангууд, гүн өрмийн худаг, гал тогооны угаалтуур унд ахуйн усны дээж авч, Ус Цаг Уур орчны Шинжилгээний төв лаборатори, SGS IMME Mongolia LLC-ийн лаборатори, МУИС-Цөмийн судалгааны төвийн лаборатори, Дорнод аймгийн Стандарт хэмжил зүйн хэлтсийн итгэмжлэгдсэн сорилтын лабораториудад хими судлал, цацраг идэвхт элемент, хүнд металлын агуулгын шинжилгээг мөн үйлдвэрлэлийн болон ахуйн бохир ус цэвэрлэх байгууламжийн цэвэршүүлсэн бохир уснаас усны дээж авч нян судлал, хими судлал, цацраг идэвхт элемент, хүнд металлын агуулгын шинжилгээг тогтмол хийлгэж байна.

Унд-ахуйн усанд нян, хими судлал, хүнд металл, цацраг идэвх элементийн дээжлэлтийг цэвэр усны эх үүсвэрийн болон хэрэглэгчийн цэгүүдэд жилд хоёр удаа дээжлэлт хийдэг. 2024 оны 10-р сарын байдлаар нийт 192 унд ахуй, ахуйн бохир,

үйлдвэрлэл, хяналтын цооног, ойр орчмын булаг, малчин айлын гар худаг зэрэг цэгүүдээс дээж авч шинжлүүлсэн байна.

Усны дээжлэлт хийхдээ Дашбалбар сумын байгаль хамгаалагч мөн хөндлөнгийн хяналтаар “Итгэлт Төгөл” ХХК-ийн мэргэжилтэн нарыг байлцуулан аргачлалын дагуу усны дээжийг авч 48 цагийн дотор Улаанбаатар хот болон Дорнод аймаг дахь итгэмжлэгдсэн лабораторид шинжлүүлэхээр илгээж байна.

2024 оны хяналт-шинжилгээний ажлын хүрээнд авсан усны дээжийг “Газрын доорх усыг бохирдуулагч бодисын зөвшөөрөгдөх дээд хэмжээ MNS6148:2010”, “Хүрээлэн буй орчин. Эрүүл мэндийг хамгаалах, Аюулгүй байдал, Ундны ус, Эрүүл ахуйн шаардлага, чанар аюулгүй байдлын үнэлгээ MNS0900:2018”, “Хүрээлэн буй орчин. Усны чанар. Хаягдал ус, Ерөнхий шаардлага MNS4993:2015” тус тус стандартуудтай харьцуулан дүгнэлт хийв.

Үйлдвэрлэлийн усны дүн шинжилгээ

2024 оны 05-р сарын 22 болон 09-р сарын 08-ны өдөр төлөвлөгөөт усны дээжлэлтүүдийг хийж гүйцэтгэсэн. Үйлдвэрлэлийн усны хүнд металлын агууламжийг “Хүрээлэн буй орчин. Усны чанар. Хаягдал ус, Ерөнхий шаардлага MNS4943:2015” стандарттай харьцуулсан. Хүснэгт 22-т үйлдвэрлэлийн усны хүнд металлын дээжлэлтийн цэгүүдийг, график 3-т үйлдвэрлэлийн усны хүнд металлын агууламжийг харуулсан байна.

Хүснэгт 22. Үйлдвэрийн усан дахь хүнд металлын дээж авсан цэгүүдийн байршил

№	Дээжний дугаар	Дээж авсан байршил
1	УС-ХМ1	Хаягдлын сангийн ус
2	УС-ХМ2	Хаягдлын сан. Хяналтын цооног ЭЖ-2
3	УС-ХМ3	Хаягдлын сан. Хяналтын цооног ЭЖ-3
4	УС-ХМ4	Хаягдлын сан. Хяналтын цооног А3
5	УС-ХМ5	Хаягдлын сан. Хяналтын цооног А2
6	УС-ХМ6	Буцах усан сан
7	УС-ХМ7	Хяналтын цооног ЭЖ-4
8	УС-ХМ8	Далд уурхайн шавхалтын ус налуу ам 945-р түвшин
9	УС-ХМ9	Дүүргэлт цехийн ус




График 3а. Үйлдвэрийн усан дахь хар тугалганы агуулга




График 3б. Үйлдвэрийн усан дахь цайрын агуулга




График Зв. Үйлдвэрийн усан дахь хүнцлийн агуулга




График Зг. Үйлдвэрийн усан дахь төмрийн агуулга




График 3д. Үйлдвэрийн усан дахь кадмийн агуулга




График 3е. Үйлдвэрийн усан дахь манганы агуулга

Далд уурхайн шавхалтын ус налуу ам 945-р түвшин буюу УС-ХМ8-д төмөр, хүнцэлийн агууламж стандарттай харьцуулахад 1.8-2.3 дахин их байна. Мөн хүнцэлийн агууламж нь хаягдлын сангийн ус буюу УС-ХМ1, буцах усан сан буюу УС-ХМ8-д стандарттай харьцуулахад 1.2-1.6 дахин их гарсан байна. Мөн буцах усан сан буюу УС-ХМ6-д манганы агууламж стандарттай харьцуулахад 1.8 дахин их байна. Хар тугалга, цайр, хүнцэл, төмөр, кадми, зэрэг хүнд металлууд нь дээжлэлтийн цэгүүдийн усны дээжинд агуулагдах боловч стандартын зөвшөөрөгдөх хэмжээнээс хэтрээгүй байна.

Ундны усны дүн шинжилгээ

Унд-ахуйн зориулалтаар ашиглаж буй гүн өрмийн худаг болон цэвэр усан сан, гал тогооны крантны ус, цэвэршүүлсэн ус мөн төслийн талбайд хамгийн ойр орших булаг зэрэг цэгүүдээс дээж авч ерөнхий хими, нян судлалын үзүүлэлтийг Дорнод аймгийн Стандарт хэмжил зүйн хэлтсийн итгэмжлэгдсэн сорилтын лабораторид, хүнд металлын агууламжийг SGS IMME Mongolia LLC-ийн лабораторид шинжлүүлдэг. Шинжилгээний дүнг “Хүрээлэн буй орчин. Эрүүл мэндийг хамгалаах, Аюулгүй байдал, Ундны ус, Эрүүл ахуйн шаардлага, чанар аюулгүй байдлын үнэлгээ MNS0900:2018” стандарттай харьцуулсан. Унд-ахуйн усны дээжлэлтийн цэгүүдийг хүснэгт 23-т, хүнд металлын агууламжийг хүснэгт 24-т, химийн үзүүлэлтийг график 4-т харуулав.

Хүснэгт 23. Уурхайн бүсийн ундны усны дээж авсан цэгүүдийн байршил

№	Дээжний дугаар	Дээж авсан байршил
1	УС-1	Гүн өрмийн 1-р худаг
2	УС-2	Гүн өрмийн 3-р худаг
3	УС-3	Гүн өрмийн 7-р худаг
4	УС-4	Баруун сүүжийн булгийн ус
5	УС-5	Цэвэр усан сан
6	УС-6	Ундны ус. Цэвэршүүлсэн ус
7	УС-7	Ундны ус. Гал тогооны крантны ус
8	УС-8	Гүн өрмийн 4-р худаг
9	УС-9	Гүн өрмийн 8-р худаг
10	УС-10	Гүн өрмийн 9-р худаг
11	УС-11	Гүн өрмийн 5-р худаг

Улааны орд төслийн төлөвлөгөөт хаврын дээжлэлтийн унд-ахуйн усны хүнд металлын агууламжийг хүснэгт 19-т үзүүлсэн байна. Үр дүнгээс харахад УС-7 буюу Ундны ус, Гал тогооны крантны усанд манган, төмөр нь стандарт хэмжээнээс хэтэрсэн байгаа хэдий ч УС-6 буюу Ундны ус. Цэвэршүүлсэн усанд манган, төмрийн агууламж стандарт хэмжээнээс хэтрээгүй байгаа нь төслийн талбайд ашиглаж буй ус цэвэршүүлэх төхөөрөмж нь хэвийн ажиллаж байгааг харуулж байна.

Унд-ахуйн усан дахь химийн үзүүлэлтийг график 3-т харуулсан байна. Үр дүнгээс харахад ундны усан дахь хлорид, усны хатуулаг болон усны орчин нь бүх дээжлэлтийн цэгүүдэд стандарт хэмжээнээс хэтрээгүй хэвийн байна.




График 4а. Ундны усан дахь хлоридын агуулга




График 4б. Ундны усан дахь хатуулаг




График 4в. Ундны усан дахь усны орчин

Улааны орд төслийн ундны усны эх үүсвэрийн худгууд, усан сан, цэвэршүүлсэн ус, цэвэр усан сан зэргээс жилд хоёр удаагийн давтамжтай дээж авч, итгэмжлэгдсэн лабораторид илгээж шинжлүүлдэг. Ундны усны хүнд металлын агууламжийг дараах хүснэгтээр үзүүлэв. /Хүснэгт 24/

	Хүнцэл As		Манган Mn		Төмөр Fe		Хар тугалга Pb		Цайр Zn		Кадми Cd	
	5-р сар	9-р сар	5-р сар	9-р сар	5-р сар	9-р сар	5-р сар	9-р сар	5-р сар	9-р сар	5-р сар	9-р сар
MNS 0900:2018	0.01	0.01	0.1	0.1	0.3	0.3	0.01	0.01	5	5	0.03	0.03
Гүн өрмийн 1-р худаг	0.00141	0.00255	0.005	<0.005	<0.05	<0.05	<0.0005	<0.0005	<0.0005	0.006	0.00001	0.00001
Гүн өрмийн 3-р худаг	0.00203	0.00287	<0.005	<0.005	<0.05	<0.05	<0.0005	<0.0005	<0.0005	<0.005	0.00002	0.00002
Гүн өрмийн 7-р худаг	0.00079		<0.005		<0.05		<0.0005		0.012		0.00006	
Баруун сүүжийн булгийн ус	0.00531	0.00667	<0.005	0.067	<0.05	<0.05	<0.0005	<0.0005	<0.0005	0.007	0.00008	0.00006
Цэвэр усан сан	0.00091	0.00092	<0.005	<0.005	<0.05	<0.05	<0.0005	<0.0005	<0.0005	0.007	0.00002	0.00002
Ундны ус. Цэвэршүүлсэн ус	0.00027	<0.0000 3	<0.005	<0.005	<0.05	<0.05	<0.0005	0.0011	<0.0005	0.022	<0.0000 1	0.00001
Ундны ус. Гал тогооны крантны ус	0.0019	0.00081	0.253	<0.005	1.155	<0.05	<0.0005	<0.0005	<0.0005	0.021	0.00004	0.00002
Гүн өрмийн 4-р худаг	0.00189	0.0052	<0.005	<0.005	<0.05	<0.05	<0.0005	<0.0005	<0.0005	<0.005	0.00005	0.00002
Гүн өрмийн 8-р худаг	0.00121	0.00257	0.006	<0.005	<0.05	<0.05	<0.0005	<0.0005	<0.0005	<0.005	0.00002	
Гүн өрмийн 9-р худаг	0.0027		<0.005		<0.05		<0.0005		<0.0005		<0.0000 1	0.00001
Гүн өрмийн 5-р худаг		0.00218		<0.005		<0.05		<0.0005		<0.005		0.00005

Хүснэгт 25. Уурхайн бүсийн ойр орчмын ундны усны дээж авсан цэгүүдийн байршил

№	Дээжний байршил	Дээжний дугаар
1	Малчин Б.Мөнхбат гүний худаг	УС-ДБО1
2	Малчин Д.Дашбаяр гар худаг	УС-ДБО2
3	Малчин Б.Батжаргал гар худаг	УС-ДБО3
4	Малчин М.Миш-Иш гар худаг	УС-ДБО4
5	Гоожуур гүний ус	УС-ДБО5
6	Эрхэтийн уурхайн тогтмол ус	УС-ДБО6




График 5а. Уурхайн бүсийн ойр орчмын ундны усан дахь хатуулаг




График 5б. Уурхайн бүсийн ойр орчмын ундны усан дахь pH




График 5в. Уурхайн бүсийн ойр орчмын ундны усан дахь магни

9.3. ХӨРСНИЙ БОХИРДЛЫГ ХЯНАХ

Хөрсний хяналт-шинжилгээ

Энэхүү хяналт-шинжилгээг хүснэгт 26-д заасан цэгүүдээс дээж авч, итгэмжлэгдсэн лабораториудад шинжлүүлсэн. Хүнд металлын дээжийг SGS IMME Mongolia LLC-ийн лаборатори, цацраг идэвхт элемент дээжийг МУИС-Цөмийн судалгааны төв лаборатори, нефть бүтээгдэхүүний дээжийг Цаг уур, Орчны шинжилгээний газар Байгаль орчин хэмжил зүйн лаборатори, нян судлалын дээжийг Дорнод аймгийн Стандарт хэмжил зүйн хэлтсийн итгэмжлэгдсэн сорилтын лабораторид тус тус жилд хоёр удаа шинжлүүлдэг. 2024 оны 10-р сарын байдлаар нийт 256 дээжийг шинжлүүлээд байна

Хөрсний хүнд металлын шинжилгээний үр дүн

Хөрсний хүнд элементүүд нь хөрс үүсгэгч эх чулуулгаас уламжлагдан мөн агаараас аэрозоль байдлаар шингэж хуримтлагддаг. Хүнд элемент нь бусад бохирдуулагчтай харьцуулахад задрах, саармагжих, цэвэрших зэрэг процесст амархан ордоггүй бөгөөд хөрсөнд удаан хугацаагаар хуримтлагдаж, дан ганц хөрсийг бус хүрээлэн буй орчныг бүхэлд нь бохирдуулдаг. Хүнд элементүүдийн дотроос хүнцэл, мөнгөн ус, хар тугалга, кадми, хром, цайр зэрэг элементүүд нь нөлөөллийн хувьд хортойд тооцогдоно.

Хөрсний хүнд металлын агууламжийг тодорхойлох, хуримтлал үүсэж байгаа эсэхийг тодруулах зорилгоор төслийн талбайд оноосон хатуу цэгүүдээс хөрсний дээж аван SGS IMME Mongolia LLC-ийн лабораторид шинжлүүлдэг. Хөрсөн дэх хүнд металлын агууламжийг график 6-д харууллаа.

Хүснэгт 26. Хөрсний хүнд металлын дээж авсан цэгүүдийн байршил

№	Дээжний дугаар	Дээж авсан байршил
1	ХӨРС-ХМ1	Буцах усан хойд тал
2	ХӨРС-ХМ2	ХӨРС-ХМ1 цэгээс хойш 250 метрт
3	ХӨРС-ХМ3	Хаягдлын сангийн баруун урд тал
4	ХӨРС-ХМ4	Баруун сүүжийн булгийн хажуугийн хөрс
5	ХӨРС-ХМ5	Ахуйн хог хаягдлын цэг
6	ХӨРС-ХМ6	Хуучин ахуйн цэвэрлэх байгууламж орчим
7	ХӨРС-ХМ7	Далд уурхайн амнаас 250 метрт
8	ХӨРС-ХМ8	Бетон зуурмагийн цехээс урагш
9	ХӨРС-ХМ9	Эдэлбэрт өртөөгүй талбай. Хусан төгөл
10	ХӨРС-ХМ10	Хүдрийн овоолго химийн бодисын агуулах
11	ХӨРС-ХМ11	Далд уурхайн хажуу дахь хусан төгөл
12	ХӨРС-ХМ12	Баяжуулах үйлдвэр хатаах цех хажуугийн хөрс
13	ХӨРС-ХМ13	Уурын зуухны баруун талын хусан төгөл
